

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2010.03.15.

Эрдэнэт хот.

Монгол улсын Засгийн газраас 2009 оныг “Үйлдвэржүүлэлтийн жил”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын Тамгын газраас “Эрдэнэт хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил” болгон зарлаж орчноо тохижуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөх, бүх шатанд сахилга хариуцлагыг сайжруулах, ажил олгогчдыг дэмжих, үйлдвэрлэл, ажлын байрны тоог өсгөх, иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод, нээлттэй хүргэх зорилт дэвшүүлэн ажиллалаа.

Нэг: Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

1.1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт

Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг аймаг, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Үндэсний хөгжлийн цогц бодлогод Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнг 2007-2015 онд Мянганы хөгжлийн зорилтыг хангах, эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, 2016-2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих хоёр үе шаттай хамтатган авч үзсэн билээ. Уг чиглэлийн хүрээнд 2007-2015 онд хэрэгжүүлэх стратегийн зорилтуудаас орон нутгийн түвшинд хэрэгжих зорилтуудыг түүвэрлэн авч, холбогдох хэлтэс, албад, сумдын Засаг дарга нарт хүргүүлэн, хэрэгжилтийг хангаж байна.

Уг ажлын хүрээнд “Орхон аймгийг 2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлого”-ыг аймгийнхаа нөөц боломжид тулгуурлан салбар салбарын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 102 дугаар тогтоолоор батлуулав.

“Орхон аймгийн хөгжлийн цогц бодлогод “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)”, “Монгол Улсын Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр (2015 он хүртэл)”, Монгол Улсын хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар тусгалаа олсон бөгөөд:

- ✓ “Эрдэнэт хотын 2020 он хүртэлх хөгжлийн стратеги”
- ✓ “Гэр хорооллыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр”
- ✓ “Орхон аймагт барилгын салбарыг 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”
- ✓ “Орхон аймгийн мэдээлэл, холбооны салбарыг хөгжүүлэх хөтөлбөр/2009-2015 он/”
- ✓ “Орхон аймагт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар 2010 он хүртэл хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө”
- ✓ “Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр/2005-2015 он/”
- ✓ “Ногоон хувьсгал дэд хөтөлбөр”
- ✓ “Газар тариаланг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр /2008-2012 он/”
- ✓ “Атрын гурав дахь аян(газар тариалангийн хөгжлийн дэд хөтөлбөр)/2008-2010 он/”
- ✓ “Аймгийн боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө /2009-2015 он/”
- ✓ “Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах талаар баримтлах бодлого/2009-2012он/”
- ✓ “Орхон аймгийн онцлогт нийцсэн Мянганы хөгжлийн зорилтууд /2009-2015 он/”
- ✓ “Эрүүл хот” хөтөлбөр/2009-2021/
- ✓ “Үйлдвэрлэл, үйлчилгээг 2009-2013 онд хөгжүүлэх аймгийн хөтөлбөр” зэрэг

аймгийн хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулсан болно.

Орхон аймгийн хөгжлийн цогц бодлогод аймгийн алсын хараа, эрхэм зорилгыг:

“Орхон аймаг нь хүний хөгжлийн түвшингээрээ улсдаа тэргүүлсэн иргэдтэй, тогтвортой хөгжлийг хангасан бүсдээ тэргүүлсэн өндөр бүтээмж бүхий эдийн засагтай, амьдралын цэвэр таатай орчинг үлгэр жишээ бүрдүүлсэн сайн засаглал бүхий аймаг болохыг эрхэм зорилго болгоно” гэж тодорхойлон тэргүүлэх чиглэлүүдийг тогтоосон. Үүнд:

1. *Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлэн “Эрүүл хот” төслийг хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.*

2. Дэлхийн жишигт хүрсэн мэдлэг боловсрол олгох, сурч хүмүүжих нөхцлийг бүрэн хангаж боловсрол, ШУ-ны салбарыг хөгжүүлнэ.
3. Уул уурхайн олборлох үйлдвэрүүдэд тулгуурлан хуримтлал бий болгож, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн орчин үеийн салбарыг хөгжүүлнэ.
4. Олон улсын стандартад нийцэхүйц, импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэл, өндөр соёлтой үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийг бэхжүүлнэ.
5. Дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.
6. Байгальд ээлтэй дэвшилтэт технологийг дэмжин, нэвтрүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

Дээрхи чиглэлүүдийг хэрэгжүүлэх 5 салбар бодлогын хүрээнд 177 дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан болно.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын аймаг, нийслэлийн түвшинд хэрэгжих стратегийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд өссөн дүнгээр 84,8 хувьтай байна.

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар шууд хариуцан хэрэгжүүлэх 149 арга хэмжээ төлөвлөгдсөн байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тодорхой асуудлуудыг тусган үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2009 оны жилийн эцсийн байдлаар гаргаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 25 арга хэмжээ бүрэн биелж, 72 арга хэмжээ 90 хувь, 35 арга хэмжээ 70 хувь, 9 арга хэмжээ 50 хувь, 5 арга хэмжээ 30 хувийн хэрэгжилттэй байна. Мөн 3 арга хэмжээний хэрэгжиж эхлэх хугацаа болоогүй байна. Хэрэгжилт удаашралтай буюу 50-аас доош хувийн хэрэгжилттэй арга хэмжээнүүд нь хөрөнгийн эх үүсвэргүй, холбогдох яамнаас хөрөнгө хуваарилагдаагүй, яамны түвшинд боловсруулж батлуулах

бодлогын баримт бичгүүд батлагдаагүй зэрэг шалтгаантай байна. Хэрэгжилтийн явц өссөн дүнгээр **82,4** хувьтай байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүнг бүлэг тус бүрээр нь авч үзвэл:

1.2.1. Нийгмийн хөгжлийн бодлого

Эрүүл мэндийн бодлогын хүрээнд:

Хүн ам нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилтыг хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилтийн механизмыг төв болон орон нутгийн түвшинд оновчтой болгох зорилгоор “Орхон аймгийн хүн амын нийгмийн эрүүл мэндийг сайжруулах талаар 2009-2012 онд баримтлах бодлого”-ыг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталлаа.

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу олон улсын тэмдэглэлт үйл ажиллагааг 14, албан бус сургалт 99, тэмцээн, мэтгэлцээн, уралдаан, уулзалт ярилцлага үзүүлэх сургууль 12, олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааг 2, зорилтот бүлгийн үйл ажиллагааг 4, үе тэнгийн сургагч нарын 6 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулан сертификат олголоо. Нийт 35 хүүхдийг үе тэнгийн сургагч хүүхдээр бэлтгэв.

Төлбөрийн чадваргүй, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлэх арга хэмжээний хүрээнд Бүсийн эмчилгээ, оношлогооны төвөөс цус харвалтын дараахь байдалтай иргэд, Хөгжлийн бэрхшээлтэй 40 гаруй хүүхдүүд, хорт хавдрын төгсгөлийн шатанд байгаа иргэдэд гэрээр нь үнэ төлбөргүй эмчийн үзлэг, сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хорт хавдрын улмаас хими эмчилгээ хийлгэж байгаа 20 өвчтөнд эмчилгээний зардалд орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг олгов.

Эрүүл мэндийн салбарын төрийн байгууллага болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх оновчтой механизмыг бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд хувийн хэвшлийн 49 эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтын ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж,

улсын болон хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан ажилтанг Эрүүл мэндийн газарт орон тоогоор ажиллуулж эхэллээ.

Өрхийн эмнэлгийн хүн амд үзүүлэх нэн шаардлагатай тусламж үйлчилгээг бүрэн үзүүлэх чадавхийг сайжруулах зорилгоор “Мөнх сүндрэл” өрхийн эмнэлгийн 1 сувилагчийг зүрх судасны чиглэлээр сургалтанд хамруулж, иргэдэд зүрхний цахилгаан бичлэг хийж байна. “Гэрэлт мандах” өрхийн эмнэлэг шинээр утлагын аппараттай болж, эмийн бус эмчилгээний хүртээмжийг сайжрууллаа.

Өрхийн эмнэлгүүд яаралтай болон анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор эмчилгээний өрөөний тохижилтонд зориулж “Ачлалт нар”, “Анхны оч”, “Мөнхсүндрэл-2” өрхийн эмнэлэг нийт 1,7 сая төгрөгөөр засвар хийж, автомакс, массажны аппарат, татлагын аппарат, сахарын тест, нийт 4.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг авч оношлогоо эмчилгээнд хэрэглэж байна.

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд багийн бага эмчийг бэлтгэж ажиллуулах, нөхцлийг сайжруулах зорилгоор Малчин багийн 1 бага эмчийг эмийн бус эмчилгээний сургалтанд хамрууллаа. Малчин багийн иргэдэд идэвхитэй эргэлт хийх авто машиныг орон нутгийн төсвөөс олгож, жилийн эцсийн байдлаар 0-5 насны 359 хүүхдийг амин дэм А-гаар хангаж, 0-1 насны 3500 хүүхэд, жирэмсэн 119, өндөр настан 589, 3018 иргэнд идэвхитэй эргэлт хийж, анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэв.

Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнийг лабораторийн шинжилгээнд үндэслэн тандах тогтолцоог үндэсний түвшинд бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд халдварт өвчний тохиолдол бүрийг лабораторийн шинжилгээнд үндэслэн тандалт хийж байгаа ба вирусын халдварын сэжигтэй тохиолдол бүрийн шинжлэгдэхүүнийг Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлэн, оношийг баталгаажуулж байна. Шувууны болон хүний томуугийн цар тахлын чадавхийг сайжруулах төслийн хүрээнд Томуугийн үндэсний төвтэй хамтран Бүсийн оношлогоо, эмчилгээний төвд вируслогийн лаборатори байгуулаад байна.

“Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 98.3 хувьтай дүгнэгдлээ.

Алсын зайн оношлогооны сүлжээг өргөжүүлж, бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг хамруулах арга хэмжээний хүрээнд Люксембургийн Зүрх судасны төслийг хэрэгжүүлэн 896 хүнд Зүрхний эхо оношлогоо хийж, зүрх судасны төв рүү зайнаас 16 удаа, төрөх

эмэгтэйчүүдийн чиглэлээр 50 хүнд оношлогоо хийн, 42 эх, 8 нярайн шинжилгээг Эх нялхсын эрдэм шинжилгээний төв рүү зайнаас дамжуулан зөвлөгөө авлаа. Уг ажлын хүрээнд Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, эмнэлэг сувилал, 6 өрхийн эмнэлгийг компьютерийн дотоод болон интернэтийн сүлжээнд холбосон нь зохих үр дүнгээ өгч байна.

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор Биеийн тамир, спортын мэргэжлийн сургалттай “Ирээдүйн одод” сургуулийг байгуулж, энэ хичээлийн жилд үйл ажиллагааг нь жигдрүүлэн ажиллаж байна. Аймгийн өсвөрийн шигшээ багийг спортын 7 төрлөөр 41 тамирчинтайгаар байгуулаад байна. Энэ онд дэлхий тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гаргасан 107 тамирчныг урамшуулахад орон нутгийн төсвөөс 8.3 сая төгрөг зарцууллаа.

Нийтийн биеийн тамир, спортын байгууллагын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, ашиглалтыг үе шаттай сайжруулах ажлын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн амралтын бааз дээр улсын шигшээ болон өөрийн баг тамирчдын бэлтгэл хийх, амжилт гаргах нөхцөл бололцоог бүрдүүлж бөхийн дэвжээ, сагсан бөмбөгийн иж бүрдэл хэрэгслээр хангасны зэрэгцээ “Сархиа” цанын баазын орчныг тохижуулж хашаатай болгов. Эдгээрт “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас 260.0 сая төгрөг зарцуулаад байна. Мөн шинээр буудлага, ширээний теннисний клубуудыг тохижуулж, ашиглалтанд орууллаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлогын хүрээнд:

Баг бүрт гэр цэцэрлэг байгуулж, хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжин сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд цэцэрлэггүй багуудад цэцэрлэг байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд бодлогын хүрээнд Их залуу багт 120 хүүхдийн цэцэрлэгийг барихаар улсын төсвөөс 450.0 сая төгрөг батлагдсаны дагуу барилга угсралтын ажил 90 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.

Өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг олгож байгаа бөгөөд тайлант онд хувийн хэвшлийн 3 цэцэрлэгт 51,4 сая төгрөг зарцуулав. Цэцэрлэгийг тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор “Тогтвортой амьжиргаа II” төслийн хүрээнд 11 цэцэрлэгт тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж олгож, энэ арга хэмжээнд 47.3 сая зарцуулав.

Жаргалант сумын цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэхэд 4.3 сая, 2, 15 дугаар цэцэрлэгийн гаднах тоглоомын талбайг тохижуулахад 10,8 сая төгрөг зарцууллаа. Боловсролын салбарт гадаад, дотоодын төсөл хэрэгжүүлж ажилласнаар Их Британийн Хүүхдийг ивээх сангаас 18-р цэцэрлэгт дүрслэх урлагийн хичээлийн иж бүрдэл, Дэлхийн банкны санхүүжилтээр 7-р цэцэрлэгт хүүхдийн ор, орны цагаан хэрэгсэл, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 2, 7-р цэцэрлэгийн тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тайлант онд цэцэрлэгүүдийн тохижилт, сургалтын хэрэглэгдэхүүнд нийт **68.3** сая төгрөг орон нутгаас зарцуулж, сургалтын орчин бүрдүүлж ажилласан байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бага боловсролын хамран сургалтын хүрээг 95,0 хувьд хүргэх зорилгоор арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд манай аймгийн хувьд 7586 хүүхэд байгаагаас ерөнхий боловсролын сургуульд 7496 хүүхэд суралцаж, хамран сургалт 98.8 хувьтай байна.

Ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангаж, тэдний мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд аймгийн багш нарын мэргэшил мэдлэгээ дээшлүүлэх орчинг бүрдүүлсэн гэж үзэж байна. Тухайлбал: Боловсрол, соёлын газрын дэргэд Байгалийн ухаан, Бага боловсрол, Биеийн тамир-Эрүүл мэнд, Технологи, Хөгжим, Мэдээлэл зүй-Зайны сургалтын төв, Солонгос хэл, соёлын төвүүдийг байгуулав. Мөн багшийн хөгжих нөхцлийг бүрэн хангасан “Мэдээллийн төв”-ийг бүх сургуулиудад байгуулж, интернет сүлжээнд холбон ашиглаж байна.

Бичиг, үсэг тайлагдалтын түвшинг ахиулах зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд нийт иргэдийн боловсролын түвшний судалгааг гаргаж, сургуульд огт хамрагдаагүй болон сургууль завсардсан хүүхдийг бүртгэлд хамруулан, Албан бус боловсрол төвд 10-35 насны 259 хүүхэд залуус суралцаж байна. Сумын төвөөс алслагдсан ядуу, нэн ядуу өрхийн хүүхдүүдээс 106 хүүхэд залуус бичиг үсгийн болон боловсрол нөхөн олгох сургалтанд дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр суралцаж байна.

Эмзэг бүлгийн өрхийн болон 3 ба түүнээс дээш хүүхэд нь сургуульд нэгэн зэрэг суралцдаг өрхүүдийн судалгааг нэгтгэн, жил бүр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлсний дагуу 2009 онд 16.3 сая төгрөгийн хичээлийн хэрэгсэл 1600 гаруй

хүүхдэд олголоо. Сурах бичгийг үнэ төлбөргүй олгох “Эрхийн бичиг”-ээр 28976 сурах бичиг олгов.

Жаргалант сумын сургууль 96, Мон-Туркийн сургууль 85, “Ирээдүйн одод” 50 хүүхэд дотуур байранд байрлуулж байгаа ба цэвэр, бохир усанд холбогдсон байртай болно. Энэ онд “Ирээдүйн одод” сургуулийн дотуур байранд Дэлхийн банкны санхүүжилтээр бэлтгэгдсэн хөнжил, гудас, цагаан хэрэгсэл болон гал тогооны тоног төхөөрөмж зэрэг 18.8 сая төгрөгийн эд хогшлийг олгоод байна. Мөн “Үр дүнд түргэн хүрэх санаачлага төсөл”-өөс Жаргалант сумын сургуулийн дотуур байрны иж бүрэн засварыг 94.0 сая төгрөгөөр хийж, гэрийн нөхцөлд ойртуулж тохижуулав.

Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуульд суралцагчдад нийтийн тээврээр үйлчлүүлэхэд хөнгөлөлт үзүүлэх бодлогын хүрээнд Оюутны унаа тээврийн асуудлыг хөнгөвчлөх чиглэлээр төрийн захиргаа, зорчигч тээврийн байгууллага, Оюутны холбооны гурвалсан судалгааг үндэслэн туршилтын журмаар ердийн тарифаас 50 төгрөгийн хөнгөлөлттэйгээр 2 маршрутад автобус явуулж туршилт хийсэн. Одоогийн байдлаар МУИС-ийн Орхон аймаг дах салбар сургуулийн оюутнуудад “ББ-Од” ХХК-ийн микро автобус 50 төгрөгийн хямдралтай үйлчилж байна.

Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газраас ажлын байр, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн идэвхи, санаачилгыг дэмжин бизнес эрхлэх орчныг бүрдүүлэх, хүн бүрийг эдийн засгийн идэвхтэй, хөдөлмөрийн чадвартай байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, ядуурлыг бууруулах зорилт тавьсан бөгөөд аймгийн хэмжээнд уг зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2009 онд аймгийн хэмжээнд 400 гаруй аж ахуй нэгжид **3155** ажлын байр бий болсноос **1903** иргэнийг ажилд зуучлан орууллаа. Үүнээс **1840** нь шинээр бий болсон ажлын байр байна. Мэргэжил олгох сургалтыг 23 удаа зохион байгуулж, 527 иргэнийг хамруулав.

Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор бүртгэлтэй ажилгүй иргэдийг авч ажиллуулж байгаа 28 аж ахуйн нэгж, байгууллагад 66 иргэн авч ажиллуулсаны цалингийн нөхөн олговорт 38.8 сая төгрөг олголоо.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 31 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ойг нөхөн сэргээх хайс хашлага хийх, мод бут, сөөг тарих, ургуулах, арчлах орчны

цэвэрлэгээ хийх, авто замын зогсоол өргөтгөх зэрэг ажлуудад 846 эмзэг бүлгийн орлого багатай иргэдийг хамруулан ажиллуулж, ажлын хөлсөнд 100.0 сая төгрөгийг зарцуулав.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон техникийн боловсролын сургуульд суралцагчдын тоог нэмэгдүүлэх зорилтыг орон нутгаас дэмжин ажилласнаар Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд өмнөх онд 1010 оюутан суралцаж байсан бол тайлант онд 1070 болж өссөн байна.

Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, төрөл, хэлбэрийг оновчтой болгох төрийн бодлогын хүрээнд “Халамжийн үйлчилгээний менежер” программыг суурилуулан, иж бүрэн мэдээллийн сантай болж, иргэдэд хөнгөн шуурхай түргэн үйлчилгээг хүргэх бүрэн боломжоор хангагдлаа. Халамжийн үйлчилгээний менежер программд Баян-Өндөр, Жаргалант сумын нийгмийн ажилтнуудыг давхар хамруулан аймгийн хэмжээнд нэгдсэн мэдээллийн сүлжээтэй болсон.

Нийгмийн халамжийн үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу хүргэх, хөрөнгийг үр ашигтай зарцуулахад хяналт тавих чиглэлээр сар бүр сумын болон бүх багуудын амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн хурлын ирц, хариуцлагатай ажиллаж, үнэн зөв санал, шийдвэр гаргаж ажилласан байдал, ажлын оролцоо, айл өрхөөр явсан нөхцөл байдлыг нь судалж, үнэн зөв судалгаа гаргасан байдал зэрэгт хяналт тавьж, дүгнэн, Баян-Өндөр, Жаргалант сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн нийт 147 гишүүдэд 6.9 сая төгрөгийн урамшуулал олголоо.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд сургалт, жижиг төсөл хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх эцэг зэрэг 100 гаруй иргэнийг хамруулж, 5.3 сая төгрөг зарцууллаа. Япон улсын Засгийн газрын ядуурлыг бууруулах сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа “Гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх” төсөл нь тодорхой багуудыг сонгон төсөл хэрэгжүүлж, Шанд, Их залуу, Эрдэнэ, Дэнж, Наран, Цагаанчулуут, Булаг зэрэг 11 багт 80 гаруй бүлэг үүсч, 1000 гаруй гишүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Наран багт нийгмийн түншлэлийн сүлжээг бэхжүүлэх төслөөс жижиг бизнес эрхлэх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 40 бүлэгт 24.0 сая төгрөгийн зээлийг олгов.

Хүүхэд өсвөр үеийнхний зохистой хооллолтыг дэмжих зорилгоор улирал бүр мэргэжлийн байгууллага, хүмүүстэй хамтран “Үдийн цай” хөтөлбөр болон цэцэрлэгүүдийн цайны газрын үйл ажиллагаа, хоолны илчлэг чанар, эрүүл ахуйн стандартад тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Тамхины хор хөнөөлийг сурталчлах, өсвөр насны хүүхдийг тамхи татахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд өсвөр үеийнхнийг тамхи хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Ахмадын бие даасан сувиллыг барьж байгуулах ажил 2008 онд эхэлж ажлын гүйцэтгэл 80 орчим хувь хийгдсэн боловч 2009 онд хөрөнгийн эх үүсвэргүйгээс уг ажил бүрэн зогссон. Засгийн газар, холбогдох бусад байгууллагуудад удаа дараа хүсэлт тавьсаны үр дүнд дутуу барилгад шаардлагатай 105,0 сая төгрөгийн санхүүжилтийг 2010 оны улсын төсөвт батлууллаа.

1.2.2. Үйлдвэржүүлэлтийн бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах зорилт

Макро эдийн засаг, санхүүгийн бодлого

Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Аймгийн төсөвт 32.5 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөө 110,2 хувиар биеллээ. Хүн амын орлогын албан татварын төлөвлөгөө 1.7 хувиар, хөрөнгийн орлого 8.8 хувиар тасарч, татварын орлого 7.2 хувиар, татварын бус орлого 56.3 хувиар давж биелэсэн байна. Өнгөрсөн оноос орон нутгийн төсвийн орлого 4.4 хувиар нэмэгдлээ. Аж үйлдвэрийн салбарт 875.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 886.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж өмнөх оноос үйлдвэрлэлт 14.2 хувиар, борлуулалт 15.3 хувиар буурлаа.

Нийт бүтээгдэхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр тооцоход 301.5 тэрбум төгрөг болж 95.6 хувийг уул уурхайн олборлох салбарт, 3.1 хувийг боловсруулах салбарт, 1.3 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэлээ.

Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож, дунд болон урт хугацааны бодлогыг

хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах бодлого баримтлан ажиллаж байна. Төсвийн төслийг боловсруулахдаа аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад хөтөлбөр төслүүдэд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх чиглэл баримталаа. Тайлант онд орон нутгийн болон улсын чанартай зам шинэчлэлд 1,3 тэрбум төгрөг, ДЦС-ын уурын зуухны шинэчлэлийн зардалд 1.2 тэрбум, 120 хүүхдийн цэцэрлэгийн барилга 450.5 сая, ЕБС, МСҮТ, Их дээд сургуулийн засварт 335.0 сая, Нэгдсэн эмнэлгийн гүний худгийн холболт 170.0 сая, 40 ортой эмнэлгийн барилга, Хүүхдийн ордны барилга нийт 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдлээ.

Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх үндэсний тооцооны шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хүрэх түвшин, хөрөнгө оруулалтын хэрэгцээг оновчтой тодорхойлж, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийн тэнцвэрийг бататгах макро эдийн засгийн зохицуулалтын орчныг сайжруулах арга хэмжээний хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажил олгогчдыг дэмжин ажилласнаар аймгийн хэмжээнд 2009 онд 400-аад аж ахуй нэгжид **3155** ажлын байр бий боллоо. Сүүлийн 2 жилд 2101 түр болон байнгын ажлын байр шинээр бий болсон байна

Үйлдвэржүүлэх бодлого

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Үйлдвэржүүлэх бодлогын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын хариуцан хэрэгжүүлэх 9 арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд эдгээр ажлуудыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж байна.

Боловсруулах үйлдвэрийн Монгол брэндийг бий болгож, ноолуур, хонь, тэмээний ноос, арьс, ширэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

Аймгийн “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж Үйлдвэржүүлэлтийн жилийн нээлт, Эрдэнэт хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн ажлын нээлтийг хийлээ. Мөн орон нутгийн ЖДҮ-ийн хөгжил өнөөгийн байдал, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх чиглэлийн талаар 700-аад иргэдээс санал асуулга авч

нэгтгэн дүгнэлт гарган ажиллалаа. Аймгийн “Үйлдвэрлэл, үйлчилгээг 2009-2013 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-ын Ү хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж байна.

Орон нутагт хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын чиглэлийг гарган Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн “Орхон аймагт хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэл”-ийг баталсан. Тэргүүлэх чиглэлд

1. Уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэг, технологийн материалын үйлдвэр,

2. Барилгын материалын үйлдвэрлэл

3. Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдэд түшиглэсэн үйлдвэрлэл, өндөр ашиг шимтэй эрчимжсэн аж ахуй, агро паркийг дэмжин хөгжүүлэхээр тогтлоо.

Аймгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих санд 2009 онд аймгийн дэд комисс нийт 4750.4 сая төгрөгийн 160-аад иргэн аж ахуйн нэгжийн төсөл хүлээн авч хэлэлцэн 2042.0 сая төгрөгийн 91 төслийг дэмжин банканд хүргүүлсэн ба үүнээс 46 төсөлд 780.0 сая.төгрөгний зээл олголоо. Мөн барьцаа хөрөнгө шаардлага хангахгүй байсан жижиг , дунд үйлдвэр эрхлэгчдэд БНЭЗДХ-ийн зээлийн баталгааны сангаас дэмжлэг үзүүлж 38 иргэн аж ахуйн нэгжийн 615,0 сая төгрөгийн төсөлд 232,0 сая төгрөгийн зээлийн баталгаа гаргаж, зээл олгуулав.

Нийт зээл олгосон төслийг салбараар нь ангилвал хөнгөн үйлдвэрийн 20 төсөлд 352,3 сая төгрөг, хөдөө аж хуйн 11 төсөлд 188,2 сая төгрөг, хүнсний үйлдвэрийн 6 төсөлд 142,0 сая төгрөг, ахуйн үйлчилгээний 6 төсөлд 76,0 сая төгрөг, барилгын материалын үйлдвэрийн 2 төсөлд 6,5 сая төгрөг, үйлчилгээний 1 төсөлд 15,0 сая төгрөгийг тус тус олгогдсон бөгөөд нийт 182 ажлын байр шинээр бий боллоо.

Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Завхан аймгуудад үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад шаардлагатай дэд бүтцийг байгуулах Засгийн газрын бодлогын хүрээнд Говил багийн автозам болон төмөр зам, инженерийн хангамж, дэд бүтцэд тулгуурлан үйлдвэрлэл технологийн парк байгуулахаар хил хязгаарыг тогтоож, техник, эдийн засгийн үндэслэл, шаардлагатай тооцоо судалгааг хийж холбогдох яамд, дээд шатны байгууллагад хүргүүлээд байна.

Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлого

Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, сүү, гурил, төмс, гол нэрийн хүнсний ногоогоор бүрэн хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр 5 арга хэмжээ Засгийн газрын үйл ажиллагааны

хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд уг ажлын хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулж дараахь үр дүнд хүрлээ. Тухайлбал:

“Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор манай аймгийн хэмжээнд “Эрдэнэт хаан сүү”, “Эрдэнэт шанд” ХХК-иуд үнээний цэвэр сүүг үйлдвэрийн аргаар боловсруулан сүүн ундаа, тараг, зайрмаг, цөцгий үйлдвэрлэн хэрэглэгчдийн хэрэгцээг хангаж байна.

“Хаан сүү” үйлдвэр хоногт 500 литр сүү ариутган савлаж худалдаанд нийлүүлж байна. Мөн “Төгс бурзай” ХХК “Сүү төслийн нэгж”-ээс гэрээний дагуу хоногт 500 литр сүүг савлан ариутгадаг бага оврын сүү боловсруулах тоног төхөөрөмжийг ашиглалтанд орууллаа. Үүний үр дүнд жилд 365.0 мянган литр сүү буюу аймгийн сүүний хэрэгцээний 6.9 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан ундны цэвэр сүүгээр, сүүн бүтээгдэхүүний 6,1 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнээр хангаж байна.

Энэ нь хүн амын нийт хэрэгцээт сүү, сүүн бүтээгдэхүүний 13.0 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулж хангах нөхцөл бүрдлээ. Тайлант онд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ХХААЯ-аас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар Эрдэнэт хаан сүү ХХК-д 35.0 сая төгрөг, Эрдэнэт-Оргил ХХК-д 15.0 сая төгрөгийн удаан хугацаатай, хүүгүй зээл олгосон ба зээлийн ашиглалт, үр ашгийн байдалд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд “Чацаргана” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Элсэн буйр” ХХК, “Те-Ён” ХХК-ийн чацаргана төслүүдийг шалгаруулан ХХААХҮЯаманд хүргүүлж, чацаргана, жимс, жимсгэнэ тариалах талаар иргэд, аж ахуйн нэгжид мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч байна.

Хүн амын дунд хийсэн баяжуулсан хүнсний судалгааны дүнг нэгтгэж гаргасан ба баяжуулсан гурилын хэрэглээ 78,0 хувь, баяжуулсан гурилын ач холбогдлын тухай мэдлэгийн түвшин 17 хувь, иоджуулсан давсны хэрэглээ 94 хувь, мэдлэгийн түвшин 82,0 хувьтай байна. “Хүнсний тогтвортой баяжуулан нийгмийн эрүүл мэндийг сайжруулах нь” төсөлд “Алтан тошлой”, “Хос тав” үйлдвэрүүд хамрагдан, баяжуулахад шаардагдах холигч төхөөрөмж, пермексийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгож тус үйлдвэрүүд нийт 800 тн баяжуулсан гурил үйлдвэрлэн хүн амын хэрэгцээнд нийлүүллээ.

“Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд өрхийн тариалан эрхлэгчдэд 1.5 тн санте сортын төмс, 7 нэрийн 62 кг хүнсний ногооны үрийг хуваарилан олголоо.

Баян-Өндөр, Жаргалант сумын 1500 гаруй өрх газар тариалан эрхэлж, “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хөтөлбөрт хамрагдаж, ажлын байр бий болгох, өрхийн орлогоо нэмэгдүүлэх чиглэлээр ажиллав.

Жаргалант, Баян-Өндөр сумдад “Агропарк” төслийг хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулж гурвалсан гэрээ байгуулан төслийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллалаа.

Төсөл хэрэгжүүлэгч иргэнд 0.3-0.03 га талбайг Засаг даргын захирамжаар эзэмшүүлж зоорь, хүлэмжийг барьж лооль, өргөст хэмх зэрэг хүнсний ногоо тариалж, 40 тн хүнсний ногоо хадгалж байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх “Атрын 3 дахь аян”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, усалгаатай тариалан эрхлэх, техникийн парк шинэчлэлтийн бодлогыг боловсруулж, техник, технологийн шинэчлэл хийх ажлыг эрчимжүүлж, хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлнэ. Шинэ төрлийн таримал тариалах, үр сортын шинэчлэл хийх, таримал ургамлыг хамгаалах тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд:

Тариалангийн талбайд бүртгэл тооллого явуулж, эзэмшилт ашиглалтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Аймгийн хэмжээнд 5401 га талбайн 4228 га талбайг үр тариа, 761 га талбайг төмс, хүнсний ногооны зориулалтаар ашиглаж байна. Өөрийн аймгийн тариалангийн талбайг ашиглахын зэрэгцээ зэргэлдээ аймаг, сумдаас тариалангийн зориулалтаар газар ашиглаж байна. Үр тариа тариалах талбайн хэмжээ өмнөх оноос 50 гаруй хувиар нэмэгдлээ.

“Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд улаан буудайн нөөц бүрдүүлэх хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр техникийн шинэчлэл хийх, хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох, улаан буудайн үр, ургамал хамгааллын бодисыг хөнгөлөлттэй зээлээр олгох, уринш, тариалалтын шатахуун зээлээр олгох, улсад тушаасан улаан буудайнд урамшуулал олгох, тариалангийн талбайн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах зэрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд улаан буудай тариалж байгаа талбайн хэмжээ өмнөх оныхоос 50 гаруй хувиар боловсруулах уриншийн хэмжээ мөн 50 орчим хувь нэмэгдлээ.

Үүнээс гадна газар тариаланд техникийн шинэчлэл хийх, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх чиглэл баримтлан ажилласнаар Жаргалант сумын “Бүтлийн ундарга” ХХК, “Орхон тариа” ХХК, “Алтан тошлой” ХХК Атрын III аяны хөнгөлөлттэй зээлүүдэд хамрагдаж 60 хувийн техник шинэчлэл хийлээ. Аймгийн хэмжээнд нийт 1

746,2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авснаас 514,4 сая төгрөгөөр 40 га-гийн услалтын систем барьж, үр тарианы том оврын трактор 2, бага оврын трактор 2, үтрэмийн ЗИС-60 1, хавагч 1, үрлэгч 1-ийг авлаа.

“Бүтлийн ундрага” ХХК 140 га-ийн услалтын систем 620,0 сая төгрөгөөр, Т-150 трактор 49,0 сая, хор цацагч 8,0 сая, 2 ш комбайн 56,6 сая, үрлэгч 34,2 сая, үтрэмийн техник 20,0 сая төгрөгөөр, “Алтан тошлой” ХХК 50 га-гийн усалгааны систем 444,0 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэлээ.

Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд хаврын тариалалтаар 4539.0 га-д үр тариа, 672.8 га-д төмс, 436.7 га-д хүнсний ногоо тариалж, төлөвлөгөөт зорилт үр тариа тариалалт 17.1 хувь, төмс 14.4 хувиар давж биелэв.

Ургац хураалтаар үр тариа 4529.0 га-аас 11322.0 тн, төмс 672.8 га-аас 6519.4 тн, хүнсний ногоо 436.7 га-аас 4487.3 тн-ийг хураан авлаа. 1 га-аас 25.0 цн үр тариа, 96.9 цн төмс, 102.8 цн хүнсний ногоо хураан авсан нь өмнөх оноос үр тариа 2.5 цн-ээр, хүнсний ногоо 5.7 цн-ээр их, төмс 5.6 цн-ээр бага ба үр тарианы га-ийн ургац нь аймгийн хөгжлийн түүхэнд хамгийн өндөр ургац авсан жил байлаа.

Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн ажил, үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулан, сүргийн бүтцийг оновчтой байлгах бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд өсгөн үржүүлж байгаа шилмэл омог хэвшлийн 4.4 мянган хонь, 3.6 мянган ямаа, цэвэр үүлдрийн 400 гаруй эрлийз 138 үхрийг цаашид сайжруулан ашиг шимт чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний 8 нэгжийн мэргэжилтнүүдээр дамжуулан малчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Саалийн үнээний фермерийн Өндөр-Өлзийт аж ахуйд сүрэг сэлбэх зорилгоор жижиг, дунд үйлдвэрийн сангаас 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 4 иргэнд цэвэр үүлдрийн үржлийн үнээ, бух 10-ыг олгоход зуучиллаа.

Мөн шинээр гахайн аж ахуй эрхлэх нэг иргэнд Оросын цагаан үүлдрийн 15 гахай олж авахад зуучлан тусалж, малчдыг нь сургалтанд хамруулах арга хэмжээ авлаа.

Эрчимжсэн мал аж ахуйд санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг батлан, санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг 2010 оны төсөвт тусгалаа. “Тогтвортой амьжиргаа-2” төслийн санхүүжилтээр Увс аймгаас баяд омгийн үржлийн 44 хуцыг Баян-Өндөр сумын малчдад, цэвэр үүлдрийн алатау, симменталь, хар тарлан бух 5-ыг

Жаргалант сумын малчдын бүлэгт захиалгаар олгож үржилд ашиглах арга хэмжээ авлаа.

“Малын тэжээл” хөтөлбөрийг 2009 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын орлогчоор батлуулан сумдад хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулж байна. Энэ онд аймгийн хэмжээнд 9000 тн хадлан, 15 тн гар тэжээл бэлтгэхээр төлөвлөлт хийж, үүнээс хадлан Баян-Өндөр суманд 5652 тн, Жаргалант суманд 2710 тн-ыг бэлтгэв. Мал аж ахуйн өвөлжилтийн 2009-2010 оны бэлтгэл ажлын хүрээнд Сүмийн нуга хоршоо овъёос 7 га, хөх тариа 4 га, эрдэнэ шиш 1 га, судан өвс 0.5 га-д, Орхон тариа овъёос 20 га-д тариалалт хийн хурааж авлаа. Манай аймагт энэ онд бэлчээрт шинээр худаг гаргах, сэргээн засварлах зардал санхүүжилт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хуваарилагдаагүй тул бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор орон нутгийн хөрөнгөөр бэлчээрийн 2 худгийг сэргээн засварлаж, тухайн багт нь хүлээлгэн өглөө.

Дэд бүтэц, хот байгуулалтын бодлого

Газар ашиглалтыг сайжруулж, газрын шинэтгэлийг эрчимжүүлэн Монгол Улсын иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газраа өмчилж авахаар өссөн дүнгээр 13027 иргэн өргөдлөө ирүүлснээс 11509 иргэнд нийт 905.97 га газар өмчлүүлээд байна. Үүнээс 2009 онд 272 иргэнд 26.19 га газрыг өмчлүүлсэн. “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсантай холбогдуулан иргэдэд нээлттэй шууд нэвтрүүлгийг 2 удаа, гэр хорооллын багуудад сургалт, сурталчилгаа, ярилцлагыг 122 иргэнийг оролцуулан явууллаа.

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг үндэслэн 2009 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд фермерийн болон газар тариалангийн зориулалтаар газрыг эзэмшүүлэхээр төлөвлөн Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутагт төмс хүнсний ногооны зориулалтаар 11 иргэнд 7.2 га газрыг, Баян-Өндөр сумын Говил багийн нутагт фермерийн газрын зориулалтаар 1 аж ахуйн нэгжид 0.5 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар, Жаргалант сумын Жаргалант багийн нутагт Хуучин фермийн суурин дээр эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар 2 иргэн, 1 аж ахуйн нэгжид 2.5 га газрыг

төсөл сонгон шалгаруулалтаар тус тус эзэмшүүлж, 2009 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүллээ.

Нийслэл болон орон нутагт 100.0 мянган айлын орон сууц барих төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцжуулах бодлогод ахиц дэвшил гаргах зорилтын хүрээнд:

Засгийн газрын 40000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэт хотын 7 а хороололд “Хуан Таун” ХХК-ний хөрөнгө оруулалтаар 100 айлын 5 давхар орон сууц барьж ашиглалтанд оруулав. Мөн 8-р хороололд 10 га газрыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д, 10-р хороололд 23,6 га газрыг “Очир төв” ХХК зэрэг байгууллагад барилгууд баригдаж дуусах хүртэлхи хугацаагаар эзэмшүүлээд байна.

Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх чиглэлийг Эрдэнэт хотын гэр хорооллын дэд бүтэц, нийгмийн асуудлыг сайжруулах хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна. 2 а хороололд нийтийн болон коттеж маягийн амины орон сууцны хороолол барих зориулалттай 20 га газрыг “Глобал сивэлээшейн” ХХК, ОХУ-ын хөрөнгө оруулалттай Инаросс ХХК-д 4 га газрыг Говил багийн нутаг дэвсгэрт төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлээд байна.

Нягтрал сайжруулах чиглэлээр “Стройинвест” ХХК-д орон сууцны зориулалтаар 6-р хороололд 0.07 га газрыг эзэмшүүлсэн бөгөөд 12 давхар 300 айлын орон сууц, 2-р хороололд 0.02 га газрыг эзэмшүүлж, 48 айлын орон сууц тус тус барьж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар өөрийн ажилтнуудад зориулан 6-р хороололд 48 айлын орон сууц барьж ашиглалтанд оруулан, Говил багт “Талст өргөө” ХХК багш нарын орон сууцны зориулалттай 0,6 га газрыг эзэмшүүлэн 198 айлын орон сууц барих ажлыг эхлээд байна.

Орон нутгийн хөгжлийн бодлого

Эрчим хүчний төрөл бүрийн эх үүсгүүрийг ашиглан бүх сумыг байнгын цахилгаантай болгож, багийн цахилгаан хангамжийг сайжруулах, аймаг, орон нутгийн дулаан хангамжийн системийг сайжруулж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2009 онд улсын төвлөрсөн төсвийн 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Эрдэнэт дулааны цахилгаан станц” ТӨХК-ний зуухны халах гадаргуу солих, өрлөг, дулаалгын их засварын ажлыг гүйцэтгэлээ. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Говил багийн 2 хэсэг газрын дулаан, цэвэр усны шугам, Шанд багийн 17-р сургуулийн халаалтын зуухыг тус

тус шинэчилсэн. Жаргалант сумын уурын зуухны 2-ыг нь шинээр хийж, барилгын дээврийн засвар, янданг сольсон бөгөөд сумын халаалт хэвийн байна. Аймгийн Засаг даргын шийдвэрээр хотын инженерийн шугам сүлжээг 2009-2012 онд шинэчлэх ажлын төлөвлөгөө батлаад байна.

Баян-Өндөр сумын гэр хорооллын Их залуу, Эрдэнэ багт орон нутгийн 60,0 сая төгрөгийн хөрөнгөөр 63, 160 кВт-ын хүчин чадалтай цахилгааны 2 дэд өртөө, 6/0.4/0.22 кв-ын 9 км агаарын шугам барьлаа.

Сумдад нийгмийн суурь үйлчилгээний хүрээг өргөжүүлэх зорилгоор Баян-Өндөр сумын Их залуу багт 640 хүүхдийн сургууль, өрхийн эмнэлэг, Зэст багт 6-р бага сургуулийн Спорт соёлын заал барихаар зураг төсвийг боловсруулав. Нэгдсэн эмнэлгийг бие даасан цэвэр усны өөрийн эх үүсвэртэй болгохоор улсын төсвөөс 170,0 сая төгрөгийг батлуулсан бөгөөд тендер зарлан, гүйцэтгэгчийг шалгаруулж, ажлын гүйцэтгэл 80,0 хувьтай байна.

Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах зорилт

Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, нүүрсийг боловсруулах, гэр хорооллыг орон сууцжуулахад зориулж инженерийн байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, нийтийн тээврийг шинэчилж, хийн түлшинд шилжүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 2009 онд 150 аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд 34500 кг, иргэдийн хэрэгцээнд 10500 кг шатдаг хийг тус тус нийлүүлж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад хэрэглээ нэмэгдэж байна.

Байгаль орчны сайдын баталсан “Цагаан тоос” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2008-2015 оны төлөвлөгөөний дагуу дараах ажлыг гүйцэтгэж байна. Үүнд:

-Цагаан тоосыг бууруулах ажлын хүрээнд хаягдлын аж ахуйн хиймэл нуурын дагуу ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгэж байгаа “Ойн хүрээ” ХХК, Монголын ахмадын чөлөөт холбоо зэрэг газруудад БОАЖГазрын даргын 2009 оны 13 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг газар дээр нь шалгалт, тооллогыг явууллаа. Шалгалт, тооллогоор 2007-2009 онуудад “Ойн хүрээ”ХХК нь 4.9 км урттай, 28 м өргөнтэй ойн зурвас байгуулж 5 нэр төрлийн 50.0 мянга гаруй ширхэг мод бутыг тарьж ойжуулж байна. “Эх дэлбээ-2” төсийн хүрээнд 6 га газарт 27.0 мянга гаруй тарьц суулгаснаас 300 гаруй ширхэг мод ургуулсан байгаа нь хангалтгүй гэж дүгнэж цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмжийг хүргүүллээ.

-Эрдэнэт үйлдвэрээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг шинэчлэн тодорхойлох ажлыг “ЭКОС” ХХК гүйцэтгэж байна.

-Цагаан тоос хөтөлбөрийн биелэлтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан аймгийн ЗДТГ, Технологийн сургууль, “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон АНУ-ын өмнөд Дакодагийн их сургууль хамтран онол практикийн бага хурал зохион байгуулсан.

-Тоосны босолтыг дарах талаар Герман улсын LMBV компани болон бусад гадны компаниудтай хамтран судалгааны ажлыг хийж байгаа бөгөөд өмнөх жилүүдэд хийгдэж байсан ажлууд үргэлжлэн хаягдлын аж ахуйн 1а 2-р хэсгүүдэд нийт 40.9 га газрыг хар шороон хөрсөөр хучсан байна.

-Баяжуулах фабрикийн хаягдлын далангийн 1-р хэсэг, 2а хэсэг дээр өдөр бүр давхардсан тоогоор 600га талбайг усаар норгон тоосны дэгдэлтийг дарсан ба “Орхон групп” ХХК, ШУА нь цагаан тоосыг барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах боломжийг судалж, дээж аван туршилтуудыг үргэлжлүүлэн хийж байна.

Томоохон хот суурин газрын цэвэрлэх байгууламжид техник, технологийн шинэчлэл хийж, ашиглалтыг сайжруулан, стандартын шаардлага хангуулах арга хэмжээний хүрээнд 2009 онд Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн зураг төсөл хийгдэж, 2010 оны 2-р сард барилга угсралтын ажил гүйцэтгэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдаж, барилга угсралтын ажил 4-р сард эхлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрт хог хаягдлыг булшлах “Ландфиль”-ийн аргыг 2012 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. “Ландфиль”-ийн аргыг нэвтрүүлэхэд бэлтгэж байнгын ажиллагаатай диспетчерийн байршлийг өөрчлөн нүүлгэж, өвлийн байртай болгов. Хог хаягдлын нэгдсэн цэгийн эргэн тойрны хаягдлыг 1.5-2 км-ийн радиуст цэвэрлэж дотогш нь хумих ажлыг хийсэн байна.

Нэн тэргүүнд ойжуулах, нөхөн сэргээх шаардлагатай газрыг тодорхойлж нийтэд зарлан , жилд 10.0 мянган га-аас доошгүй талбайг ойжуулж, нөхөн сэргээх зорилтын хүрээнд аймгийн Засаг дарга, БОАЖ-ын сайдын хооронд байгуулсан гэрээ, БОАЖ-ын сайдын 2009 оны 15 дугаар тушаалын дагуу 150 га талбайд ойжуулалт хийх ажлын төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, “Ойн нэгж”-ийг шалгаруулсны үндсэн дээр Жаргалант сумын нутаг “Урт нүүр” гэдэг газарт 5-р сарын сүүлийн хагаст хөрсийг зурваслан хагалж 294.4 мянган ширхэг 2 настай шинэсний тарьц буюу өсвөр модоор

ойжуулалтын ажлын гүйцэтгэв. Намрын тооллого буюу амьдралтын хувийг тогтоох улсын комисс, аймгийн комисстой хамтран 9 дүгээр сарын 15, 16, 17-нд ойжуулалтын ажил, ногоон байгууламжийн тарьц суулгац, мод үржүүлгийн газрын үр бэлтгэл, тарьц суулгацын ургалтын байдалд тооллогыг явууллаа.

Тооллогоор ойжуулалтын ажлын амьдрах хувь 78.5 хувь, ногоон байгууламжийн ажлын үр дүнг сайн гэж дүгнэхийн зэрэгцээ мод үржүүлгийн газарт шинэсний тарьц 44.7 мянга, шар хуайс 35.0 мянга, хайлаас 1.5 мянга, улиас 2.0 мянга, агч 6.0 мянган ширхэгийг тоолж шинэсний үр 13 кг, шар хуайсны 8 кг, хайлаас 6 кг, монос 3 кг-г хүлээн авч нийт 30 кг үрийг улсын болон орон нутгийн нөөцөнд бүртгэж авлаа.

Аялал жуулчлалын томоохон цогцолбор барьж байгуулах арга хэмжээний хүрээнд Бурхан багшийн 100 метрийн голч бүхий дугуй хэлбэртэй, бурхан багшийн 17 метрийн өндөр алтадсан сэрэг дүрийн үндсэн байгууламжаас гадна хүндэтгэлийн хаалга, 8 суварга, амралт чөлөөт цагийн талбай, автомашины зогсоол, нийтийн үйлчилгээний цэг, талбай бүхий өвөрмөц архитектур төлөвлөлттэй, зочид буудал, музейн барилга байгууламжаас бүрдсэн цогцолборыг байгуулж байна.

Бурхан багшийн сэрэг дүр нь 90 шахам тн-ын жинтэй, 450 гаруй эд ангиас бүрдэх бөгөөд 30 тн-ын жинтэй 185 эд ангийг өнгөт металлээр цутгаж, бадыг бүрэн угсраад байна. Цогцолборын барилга угсралтын ажлын 90 орчим хувь болох сэрэг дүрийг “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн Засвар механикийн завод дээр өнгөт металлээр цутгах ажлын тал хувь нь хийгдэж сүншиг аравнайд орох бурхан багшийн зураг 10 сая, сүнгийн ном 10 сая, арц 12 тн зэрэг бэлтгэгдэж, сэрэг дүрийг алтдах хуудас алт 350000 ширхэг бэлэн болж, цогцолборын нийт ажлын гүйцэтгэл 75 гаруй хувьтай болоод байна. 2010 оны дундуур гол сүмийн барилга, түүн дээр байрлах сэрэг дүрийг цутгаж, угсарч алтдах ажлыг дуусгахаар ажиллаж байна.

Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох зорилт

Батлагдсан хууль тогтоомжийг төв, орон нутагт цаг алдалгүй хүргэх, эрх зүйн албан бус сургалтыг мэргэжлийн үндсэн дээр зохион байгуулах ажлын цар хүрээ, хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилтын хүрээнд “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ”-г ашиглан, “Төрийн мэдээлэл”, “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийг хэлтэс, агентлаг, сум, багуудаар 43-ыг захиалан ашиглалаа.

Тайлант онд “Аймгийн эрх зүйн сурталчилгааны кабинет”-ийг шинээр ашиглалтанд оруулж, тоног төхөөрөмжөөр хангалаа. Уг арга хэмжээнд нийт 30,0 гаруй сая төгрөг зарцуулав. Уг кабинетаар дамжуулан өнгөрсөн хугацаанд 53 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 750 гаруй төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдөд 12 хуулиар сургалт сурталчилгаа, эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгч, 49 байгууллагад 1800 гарын авлага материал бэлтгэж өгсөн байна. “Иргэдийн эрх зүйн хөтөч” номын шинэчилсэн хувилбарын хүрээнд эрх зүйн албан бус сургалт явагдаж байна. Орхон аймгийн эрх зүйн туслалцааны төв, Аймаг нийслэлийн эрх зүйн туслалцааны төвийн лавлах гарын авлага, нугалбар 5896 ширхэг материалыг хэвлүүлэн тарааж, орон нутгийн телевизүүдээр шууд нэвтрүүлэг хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай аймгийн удирдлагууд хуваарийн дагуу 35 удаа оролцон иргэдийн сонирхсон асуултанд хариулт өглөө.

Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, архидалт, согтуурлын хор хөнөөлийг бууруулах ажлыг идэвхжүүлэн, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах түүгээр үйлчлэхэд тавих хяналтыг чангатгаж, архинд донтох өвчтэй хүмүүсийг эмчлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгэх асуудлыг судалж шийдвэрлэх зорилтын хүрээнд:

Согтуурал нэгдсэн арга хэмжээний хүрээнд архины архаг хэрэглээтэй 170 хүнийг бүртгэл, судалгаанд хамруулж, архины архаг эмгэг өвчтэй 30 этгээдийн зардлын асуудлыг шийдвэрлэн 3 сарын хугацаатайгаар албадан эмчлэх газарт явуулав.

Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдан борлуулдаг, 393 цэг салбарт аттестатчлал явуулж, Засаг даргын захирамжаар 73 цэг салбарын үйл ажиллагааг бүрмөсөн зогсоож, 15 цэгийн үйл ажиллагааг түдгэлзүүлэв.

Орхон аймгийн хэмжээнд 2009 онд 106 хүн согтуугаар гэмт хэрэг үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23,4 хувиар буурлаа.

Иргэний нийгэм, төрийн удирдлагын бодлого

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангасан, иргэнд үйлчлэх үндсэн чиг үүрэг бүхий, авилга, хүнд суртлаас ангид, чадварлаг, хариуцлагатай төрийн албыг хөгжүүлэх чиглэлээр эрх зүйн

зохицуулалтыг боловсронгуй болгож, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүнд сурталгүй болгож, хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

УИХ-ын 2002 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг ХХААЖДҮГ, Тээвэр, авто замын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Биеийн тамир спортын газар, ГХБХБГазар, Хүүхдийн төлөө хэлтэс, Хотын Захирагчийн албаны дарга, Гэр бүлийн ордон ОНӨҮГ-ын захирал, Номын төвийн захирал, Баян-өндөр сумын Хүүхэд залуучуудын төвийн эрхлэгч, Жаргалант сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, Хүн эмнэлгийн эрхлэгч, Соёл мэдээллийн төвийн эрхлэгч зэрэг 14 төсвийн ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх удирдах ажилтан болон БТСГ-ын албаны даргыг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж томиллоо.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс Шведийн төрийн захиргааны олон улсын институт /SIPU internial/-тай хамтран хэрэгжүүлж буй “Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал” сургалтын хөтөлбөрийн хүрээнд тус аймагт 5 удаагийн үндсэн сургалт зохион байгуулагдан 100 ерөнхий менежер манлайлах ур чадварыг хөгжүүлэх сургалтанд хамрагдлаа. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “Ёс зүйт манлайлал” сургалтад 20 ерөнхий менежер, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран зохион байгуулсан “Үйлчилдэг удирдлага” сэдэвт сургалтад 35 ерөнхий менежерүүд тус тус хамрагдлаа. Манлайллын мастер сургагчаар 3 төрийн албан хаагчийг бэлтгэн сургалтыг зохион байгуулж байна

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газар нь “Чанарын удирдлагын иж бүрэн тогтолцоо ISO 9000 олон улсын стандарт”-ыг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрэгжүүлэх зорилгоор зохих стандартын шаардлагын дагуу бэлтгэлийг хангаж байна.

Цаашид орчин үеийн менежментийг төрийн албаны стандарт, хууль журамд нийцүүлэн хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, алдаа доголдлыг бууруулах, дотоодын аудитыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан “Чанарын удирдлагын хороо”-г байгуулан ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл зэрэг төрийн төв байгууллагуудтай хамтран “Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Өнөөдрийн хүнд суртал маргаашийн авлигын үндэс”, “Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөлт хийх”, “Төрийн захиргааны байгууллага ба төрийн албаны хаагчийн ашиг сонирхлын зөрчил”, “Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төрийн албан хаагчийн үүрэг”, “Авлигын тодорхойлолт, үнэлгээ, авлигатай тэмцэх бодлогын хандлагууд”, “Төрийн захиргааны байгууллага дахь авлигын хэлбэрүүд, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам”, “Төрийн байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангахад анхаарах асуудлууд”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн соёл, манлайлал” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулан давхардсан тоогоор 400 гаруй төрийн албан хаагчийг хамрууллаа.

Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын зорилт

Нээлттэй олон тулгуурт улс төр, эдийн засгийн дипломат гадаад бодлогын хүрээнд ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн түншлэлийн, АНУ, Япон, Европын холбоотой иж бүрэн түншлэлийн харилцааг, бусад улс орнуудтай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд:

ОХУ-ын Улаан-Үд хоттой байгуулсан удаан хугацааны хамтын ажиллагааны гэрээний дагуу 2009 онд эдийн засаг, нийгмийн чиглэлээр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж байна.

Хурлын даргын орлогч бөгөөд мандат, ёс зүйн хорооны дарга С.И.Шабакова тэргүүтэй депутатуудын бүрэлдэхүүн 2009 онд манайд айлчлан, аймгийн хурлын байгууллагын үйл ажиллагаатай танилцан, ИТХ-ын дарга болон төлөөлөгчидтэй уулзан цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцсан ба Улаан-Үд хот болон Орхон аймгийн хурлын байгууллагын хамтын ажиллагааг улам идэвхжүүлэхээр тохирлоо.

Улаан-Үд хотын Ахмадын зөвлөлийн дарга В.В.Фалилеев тэргүүтэй 10 ахмадуудыг 2009 оны 7-р сард аймгийн ахмадын саам эмчилгээнд амраалаа. Мөн Орхон аймгийн 150 хүүхдийг Улаан-Үд хотноо Байгаль далайн эрэгт хүүхдийн зусланд амраахын зэрэгцээ мөн Улаан-Үд хотын төдий тооны хүүхдүүдийг “Найрамдлын Эрдэнэс” зусланд солилцон амраав.

2009 оны 09-р сард зохиогдсон Улаан-Үд хотын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд аймгийн Засаг дарга болон ИТХ-ын нарийн бичгийн дарга тэргүүтэй аймгийн хурал, захиргааны байгууллагын төлөөлөгчид оролцлоо.

БНХАУ-ын ӨМӨЗОрны Хөх хотын Хятад-Монголын эмнэлэгтэй 2006 онд аймгийн ЭМГ-аас байгуулсан гэрээний дагуу 2009 онд 14 хоногийн хугацаатай сувилахуйн чиглэлээр сургалт, дадлагажилтанд 2 сувилагч хамрагдлаа.

Монгол улс, БНХАУ-ын хооронд найрамдалт харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд харилцаа, хамтын ажиллагаат БНХАУ-ын Бугат хоттой байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу тус хотын соёлын хэлтсийн дарга тэргүүтэй төлөөлөгчид, Манхайн театр болон зургийн хүрээлэнгийн уран бүтээлчид 2009 оны 10-р сарын 14-нөөс 18-ны хооронд манай аймагт айлчлан уран зургийн үзэсгэлэн гаргаж, уран бүтээлийн тоглолтоо аймгийн иргэдэд толилууллаа.

“Эгч дүү хотууд” болох Аляск мужийн Файрбанк хоттой байгуулсан гэрээний дагуу манай аймаг дахь Технологийн сургуулийн 2 оюутан хөнгөлөлттэй /40.000 ам.долларын төлбөрөөс чөлөөлөх/ нөхцөлөөр Аляскийн их сургуулийн Файрбанк хотын салбар сургуульд 2009 оны 1-р сараас суралцаж эхэлсэн болно.

БНСУ-ын аль нэгэн хоттой харилцаа, хамтын ажиллагаа тогтооход дэмжлэг үзүүлэхийг хүссэн Засаг даргын албан захидлыг Монгол улсаас БНСУ-д суугаа Элчин сайд болон БНСУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд Жон Ил нарт илгээсэн бөгөөд Солонгосын Элчин сайдын яамнаас Солонгос улсын Пухан, Чанвон, Пёнтэк зэрэг хотуудад Эрдэнэт хоттой “Ах дүү” хотууд болох санал илгээсэн талаар мэдэгдсэн ба энэхүү шугамаар 2009 оны 10-р сард БНСУ-ын Хвансон хотын төлөөлөгчид манайд айлчлан, аймаг орон нутгийн ажил байдалтай танилцсан болно.

Хамтын ажиллагааны гэрээний дагуу 2009 оны 8 дугаар сард аймгийн уран бүтээлчид болон төлөөлөгчид БНУУ-ын Сэкэшфэхервар хотын захиргааны урилгаар тус хотноо зохион байгуулагдсан ардын урлагийн олон улсын наадамд амжилттай оролцлоо.

1.3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас батлан хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөрүүдийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд үндэсний хөтөлбөрүүдийг эрхлэх асуудлын хүрээний агентлаг бүрт

хариуцуулан хэрэгжилтэнд хяналт тавьж, жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж ирлээ.

Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулж, аймгийн ИТХ болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2009 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд орон нутгийн онцлогоос хамаарч 64 үндэсний хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд 2003-2009 онд батлагдсан аймгийн 23 дэд хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнээс тайлант онд 8 дэд хөтөлбөр боловсруулан батлууллаа.

Тайлант онд аймгийн хэмжээнд үндэсний хөтөлбөрүүдийн биелэлт **86.7** хувь байна. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган ажилласнаар тайлант онд доорхи үр дүнд хүрлээ. Тухайлбал:

- ✓ Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Үйлдвэрлэл, үйлчилгээг 2009-2013 онд хөгжүүлэх аймгийн хөтөлбөр”-ийг батлан гаргав.
- ✓ Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийн хүрээнд Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр, Хабитат-Монгол, Дэлхийн зөн зэрэг гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажилласнаар тайлант онд нийтдээ 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгийн санхүүжилт хийж, 615,0 сая төгрөгийн зээлд 232,0 сая төгрөгийн баталгаа гаргалаа.
- ✓ Монгол улсын хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн эрх зүйн туслалцааны төвийг байгуулан ажиллах нөхцлийг бүрдүүлж, иргэдэд үнэ төлбөргүй өмгөөллийн болон эрх зүйн анхан шатны туслалцаа үзүүлж байна.
- ✓ Эрх зүйн туслалцааны төвөөс хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөөг 2009 онд 1000 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өгөв.
- ✓ “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр II”-ийн хүрээнд Ноосоор бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хоршоод болон өрхийн үйлдвэрлэгчдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нийт 8 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 4 хоршооны нийт 128 гишүүн болон өрхийн үйлдвэрлэгчдийг хамрууллаа.

- ✓ “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2009 онд улаан буудайн хэрэгцээг 13 хувь, төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний хэрэгцээг 62 хувийг хангах зорилт тавьж улмаар улаан буудайн 23 хувь, төмсний 140 хувь, хүнсний ногооны 72 хувийг тус тус хангалаа.
- ✓ “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн “Хүнсний баталгаат байдал” дэд хөтөлбөрийг боловсруулан баталж, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих аймгийн салбар зөвлөлийг байгуулав.
- ✓ Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ахуйн болон зам тээврийн ослоос сэргийлэх чиглэлээр радиогоор 6 удаа эмчийн зөвлөгөө, Шинэ мэдээ сонинд мэдээлэл, “Хүүхэд хөгжил” сэдвээр 2 телевизийн нэвтрүүлгийг бэлтгэн хэвлэж, нэвтрүүллээ. “Эрүүл мэнд бүх нийтийн үйлс” 3 сарын аяны хүрээнд 28 албан байгууллага, аж ахуйн нэгжийн эмч, арга зүйч нарт анхан тусламж үзүүлэх сургалт зохион байгуулж, гарын авлага материалаар хангалаа.
- ✓ Монголын уламжлалт бий биелгээ хөтөлбөрийн хүрээнд биет бус соёлын өвийг тээгч ардын авъяастнуудын судалгааг гаргаж, Монгол ардын язгуур урлагийн “Бий-Биелэг” холбоо Орхон аймагт салбараа нээсэн зэрэг тодорхой үр дүнгүүд гарч байгаа боловч үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг орон нутагт бий болгох зайлшгүй шаардлага байна. Үндэсний хөтөлбөрүүдийн санхүүжилт эрхлэх асуудлын хүрээний тухайн сайдын багцаар дамжин хэрэгжихээр батлагдаж, хуваарилагдаж байгаа нь орон нутагт хэрэгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэргүйгээс хэрэгжих боломжгүй болох, хэрэгжилт удаашрахад хүрч байна.

**Хоёр: Бодлогын зорилтын
хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ**

2.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцан хэрэгжүүлэх 9 арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд эдгээр арга хэмжээг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж, тайлант хугацаанд 95,1 хувь хэрэгжлээ.

Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин төрөлжсөн үзэсгэлэн худалдаануудыг зохион байгууллаа. Үүнд: “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 339 дугаар захирамжаар “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Алтан намар-2009” шинэ ургацын өдрүүд, “Эрүүл хүнс-2009” сүү, цагаан идээний үзэсгэлэн худалдааг 7 хоногийн турш зохион байгуулж, үзэсгэлэнд хүнс үйлдвэрлэгч 29 аж ахуйн нэгж, иргэн, төмс хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг 24 иргэн, аж ахуйн нэгж оролцон, өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд сурталчилан борлууллаа. Өрхийн газар тариалан эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг ард иргэдэд ойртуулан борлуулах, тэдний үйл ажиллагааг дэмжих зорилгоор аймгаас 6 багийн нутаг дэвсгэрт цэг нээж, талбайн татвар, түрээс авалгүйгээр сарын хугацаатай үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр ЖДҮ-ийг дэмжих сангаас сүүний үнээний фермер байгуулах, өргөтгөх 9 нэгжид 175.0 сая, махны үхрийн нэг аж ахуйд 13 сая, гахайн нэг аж ахуйд 6 сая, тахианы нэг аж ахуйд 35 сая, бүгд 12 аж ахуйн нэгжид 229 сая төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй дунд хугацааны зээл олгож туслалцаа үзүүлээ. Энэ нь иргэдийг экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангахад зохих хувь нэмэр оруулж байна.

Манай аймгийн хэмжээнд Эрдэнэт хаан сүү, Эрдэнэт шанд ХХК-иуд үнээний цэвэр сүүгээр үйлдвэрийн аргаар боловсруулсан ариутгасан сүү, сүүн ундаа, тараг, зайрмаг, цөцгий үйлдвэрлэн сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд болон хүн амын хэрэгцээг эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай, амин дэмээр баялаг бүтээгдэхүүнээр хангаж байна. Мөн “РТТМ” ХХК-д сүү боловсруулах цех, сүү хөргөх хөргөлтийн тоног төхөөрөмж авахад нь дэмжлэг үзүүлж ЖДҮ-ийг дэмжих сангаас 30.0 сая.төгрөгийн зээл олголоо. Ингэснээр хоногт 500-1000 л буюу жилд 165.0 мян.л сүүнд анхан шатны боловсруулалт

68м² талбайд цэцэг тарьсан. Аймгийн аж ахуйн нэгж, байгууллагууд 4 нэр төрлийн 1081 мод, 6 нэр төрлийн 948 бут сөөг орчиндоо тарьж арчилгаа усалгаа хийж байна. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх намрын ажлын хүрээнд нийтийн эзэмшил газар 3 нэр төрлийн 465 мод, 4 нэр төрлийн 1927 бут, сөөг, 2 нэр төрлийн 6740 бут, сөөгөөр ургамлын хашлага хийж намрын цэнэг усалгааг технологийн дагуу гүйцэтгэлээ. Аймгийн хэмжээнд гэр хорооллын айл өрхүүд өөрийн хашаандаа 16542 мод, 921 бут, сөөг тарьж ургуулаа. Мөн 2009 онд Жаргалант суманд 150 га газрыг ойжуулав.

Орхон аймгийн Засаг дарга, Жаргалант сумын Засаг дарга, Жаргалант сумын Шувуутын амны булгийн эхийг хамгаалж, тохижуулав. Аймгийн гадаргын усны тооллого явуулж, гол горхи 4, булаг шанд 19, рашаан 3, нуур тойром 4, нийт 30 уст цэг хамрагдлаа. Тооллогын дүнг үндэслэн 1:100000 масштабтай зураг дээр булаг, шандын байршлыг буулгаж усны мэдээллийн сан болон уст цэгийн бүртгэлд оруулж, нэгдсэн тайланг гарган Усны Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, мэдээллийн санд бүртгэж авлаа.

2009 онд улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Шувуутын амны булгийн эхийг хамгаалж, тохижуулав. Аймгийн гадаргын усны тооллого явуулж, гол горхи 4, булаг шанд 19, рашаан 3, нуур тойром 4, нийт 30 уст цэг хамрагдлаа. Тооллогын дүнг үндэслэн 1:100000 масштабтай зураг дээр булаг, шандын байршлыг буулгаж усны мэдээллийн сан болон уст цэгийн бүртгэлд оруулж, нэгдсэн тайланг гарган Усны Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, мэдээллийн санд бүртгэж авлаа.

Бэлчээрийн худгийн ашиглалтанд 2 удаа үзлэг, тооллого хийж 84 худаг, уст цэгээс шаардлагатай 2 худагт урсгал засвар хийж ашиглалтанд орууллаа. Мөн Баян-Өндөр сумын 4 худагт 4.3 сая төгрөгийн, Жаргалант сумын 2 худагт 2.0 сая төгрөгийн засвар хийж ашиглалтанд орууллаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас Мэргэжлийн сургалт, үйлдвэрлийн төвүүдийг шалгуураар үзүүлэлтээр шалгасан ба аймгийн Мэргэжлийн сургалт,

Засгийн газрын дээрхи тогтоол, хуралдааны тэмдэглэл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийн явцад улирал тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байгаа бөгөөд 2009 оны жилийн эцсийн байдлаар бүрэн биелсэн 64, 90 хувийн хэрэгжилттэй 73, 70 хувийн хэрэгжилттэй 22, 50 хувийн хэрэгжилттэй 4, 30 хувийн хэрэгжилттэй 6 заалт байгаа бөгөөд хэрэгжилтийн хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна.

Тайлангийн хугацаанд Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт 88,1 хувь байна.

Засгийн газраас 2009 онд 378 тогтоол батлагдсан гарснаас нийтээр дагаж мөрдөх, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон заалт бүхий нийт 22 тогтоолыг хяналтанд авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав. Тухайлбал:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс аймгийн Засаг дарга хариуцан хэрэгжүүлэх 149 арга хэмжээг хяналтанд авч холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн явц өссөн дүнгээр 81,9 хувьтай байна.

Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай 05 дугаар тогтоолын хүрээнд “Нийтийн биеийн тамир-Эрүүл мэнд” аяны хүрээнд аймгийн хэмжээнд нийтийг хамарсан биеийн тамирын арга хэмжээг салбарын агентлагууд хариуцан сар, сарын төлөвлөгөөтэй ажиллаж ирлээ. 2 дугаар сард “Автомашингүй өдөр” зохион байгуулснаас гадна “Цасны баяр” арга хэмжээ хийж, 39 багийн 1000 гаруй тамирчид оролцсон бол 3 дугаар сард “Биеийн тамир, спортыг дэмжигч ажлын байр” хөдөлгөөн өрнүүлэн, төрийн албан хаагчдын дунд явган аялалын тэмцээн, нийтийн алхалт, үйлдвэр албан байгууллагын арга зүйч 9 байгууллагын 80 хүн хамруулсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулж, ажлын байрны дасгал хөдөлгөөний 70 СД түгээлээ. 4 дүгээр сард “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Спорт цогцолбор хариуцан үйлдвэрийн цехүүдийн дунд олон арга хэмжээ зохион байгуулж, нийт 5365 хүүхэд, залуучууд, албан хаагчид хамрагдсан бол 5-р сард аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцан, бүх нийтийн гүйлт зохион байгуулж, 600 хүн хамруулав. Эдгээр арга хэмжээний үр дүнд Засгийн газраас “Биеийн тамир-Эрүүл мэнд” уриан дор явагдсан нийтийн биеийн тамирын хөдөлгөөнийг дүгнэж, манай аймаг улсын хэмжээнд тэргүүн байр эзэллээ.

Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай 13 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамж гаргаж Баян-Өндөр сумын бүтэц орон тоог 20, Жаргалант сумын бүтцийг 13 орон тоотойгоор ажиллуулахаар батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 26 дугаар тогтоолын хүрээнд 50 хүртэлх ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 хувиар, 51-ээс дээш ажиллагсадтайд 50 хувиар бодож төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоолоо.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн дагуу 25 ба түүнээс дээш ажилтан албан хаагчтай аж ахуй нэгжийн судалгааг шинэчлэн гаргалаа. Орхон аймгийн хэмжээнд нийт 91 аж ахуй нэгжид 161 иргэн ажиллах ёстойгоос 108 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. 2009 онд төлбөрт 4 275,8 мянган төгрөг төвлөрүүлээд байна.

“Хүнсний баталгаат байдал” хөтөлбөр батлах тухай 32 дугаар тогтоолын хүрээнд аймгийн “Хүнсний баталгаат байдал” дэд хөтөлбөрийг боловсруулаад байна. Хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтуудыг аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тодотгон оруулж, энэ онд шаардлагатай хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц зардлаас гаргаж санхүүжүүллээ.

Мөнгөн төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 56 дугаар тогтоолын хүрээнд мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн албыг орлуулан хаах иргэдийг жагсаалтад авч, хураагдсан мэдүүлгээр тооцоход төвийн тусгай дансанд өссөн дүнгээр 20,7 сая төгрөгийг оруулаад байна. 2009 онд 5 иргэнд мөнгөн төлбөр тогтоож 1 292 400 төгрөгийг тусгай дансанд төвлөрүүллээ.

Тооны дээд хязгаар тогтоох тухай 57 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2009 онд бүгд 30 иргэн одоо албаа хааж байна. Энэ хугацаанд дүйцүүлэн алба хаагчидтай 14 хоногийн сургалт зохион байгуулан явууллаа. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлд иргэдийг бүрэн хамруулахын тулд тэднийг дуудах, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны ойн арга хэмжээний бэлтгэлийг хангах, ногоон байгууламжийн жилийн хүрээнд 800 модыг уулнаас авч аж ахуйн нэгж, байгууллагуудад хүлээлгэн өгөх, малд вакцин тарих, Аврагч-2009 тэмцээн зохион байгуулах зэрэг ажилд үүрэг гүйцэтгүүллээ.

Монгол Улсын төсвийн орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээний ангиллыг батлах тухай 99 дүгээр тогтоолын хүрээнд Орон нутгийн төсвийн нэгдсэн тайлангаар өнгөрсөн онд 64.4 сая төгрөгийн хэмнэлттэй, 24.0 сая төгрөгийн өртэй гарч байсан бол тайлант онд өр, авлага үүсгэхгүй ажилласан байна.

Ажлын байрны аттестатчиллын дүнгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 122 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажлын байрны аттестатчиллыг явуулж, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хангалттай үнэлгээ авлаа. Ажлын байрны аттестатчилалд 2 суманд үйл ажиллагаа явуулж буй 235 аж ахуй, байгууллага иргэний 368 цэг салбарын 4189 ажилтан хамрагдлаа. Үзлэгт хамрагдсан аж ахуй нэгж, байгууллагын 88,0 хувь нь ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хувьд хангалттай, 12 хувь нь хангалтгүй дүгнэгдлээ.

2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 221 дүгээр тогтоолын хүрээнд өвөлжилтийн бэлтгэл хангах тухай захирамж гаргаж, бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг Засаг даргын орлогчоор ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулан ажиллуулах арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Энэхүү захирамжаар МАА-н өвөлжилтийн бэлтгэл хангах 2009-2010 оны ажлын төлөвлөгөөг баталж, 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр сум, баг, мал бүхий нэгж, мэргэжлийн байгууллагуудад хүргүүлж биелэлтэнд нь сар бүр 2-3 удаа хяналт тавьж ажиллав. Уг захирамжийн дагуу Баян-Өндөр сум 6060 тонн, Жаргалант сум 2940 тонн, бүгд 9000 тонн хадлан бэлтгэх даалгавар өгч, бог мал бүхий нэгжүүдэд хуваарь хүргүүлж, хадлангийн бэлтгэлийг хугацаанд нь хангуулж зохион байгуулалтын арга хэмжээ авснаар 8362 тн-ыг бэлтгэж төлөвлөгөөг 92.9 хувиар биелүүллээ.

Мал сүргийг онд бүрэн оруулах чиглэлээр өмнөх жилүүдэд баримталж ирсэн чиглэлийн дагуу хил залгаа Булган, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, 5 сумын удирдлагуудтай хамтарсан уулзалтыг аймагтаа 2 удаа, сумын хэмжээнд 3-4 удаа зохион байгуулж мал сүрэг, малчдыг байршуулах, өвөлжөө, хаваржаа эзэмших, бэлчээр хадлангийн талбай ашиглах талаар хэлэлцэн тохиролцож тодорхой чиглэл, шийдвэр гаргаж ажилласнаар аймгийн нийт мал сүргийн 67.5 хувь буюу 173.0 мянган толгой малыг хил залгаа бүс нутагт өвөлжүүлж, хаваржуулж байна.

Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам батлах тухай 227 дугаар тогтоолын дагуу 2009 онд Баян-Өндөр сумын нутаг “Ар булаг”-ын хойд салаанд 422 га нутаг дэвсгэр бүхий ойн санг “Унаган байгаль” иргэдийн нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлээд байна.

Шинээр гарсан “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам”-ыг ойн сан бүхий нутаг дэвсгэрт нутагладаг малчдад сурталчилан таниулах, малчдын санал бодлыг судлах зорилгоор БОАЖГ-аас томилогдсон ажлын хэсэг Жаргалант сумын ой бүхий 13 амаар явж 46 өрхийн 90 гаруй иргэдийг хамруулан сургалт сурталчилгаа хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын орон нутагтаа хэрэгжүүлэх, зохион байгуулах талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргаж Жаргалант сумын ИТХ-ын дарга, сумын Засаг дарга нарт хүргүүлэв.

“Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-ийг Засгийн газрын 299 дүгээр тогтоолоор баталсантай холбогдуулан аймгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг байгуулж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргалаа.

Энэ ажлын хүрээнд Аймгийн “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулав. Мөн орон нутгийн Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил өнөөгийн байдал, ямар үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай байгаа талаар 700-аад иргэдээс санал асуулга авч нэгтгэн дүгнэлт гаргаж судалгааны үр дүнгээс “Үйлдвэрлэл, үйлчилгээг 2009-2013 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, аймгийн ИТХ-ын Ү хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа.

Засгийн газрын 2009 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 7 дугаар тэмдэглэлээр улсын төсвийн орлого буурч байгаатай холбогдуулан төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг тодорхой хэмжээгээр бууруулах талаар санал боловсруулан Сангийн яаманд яаралтай хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалганы дагуу

Санхүүгийн хүндрэлтэй байдлын улмаас орон нутгийн төсвөөс зарцуулах хөрөнгө оруулалт, орон нутгийн урсгал зардлын хэмжээг УИХ-аас баталж ирүүлсэн төсөв, Сангийн яамнаас өгсөн зөвлөмжийн дагуу дахин хянаж төсвийн тодотгол хийж аймгийн ИТХ-аар батлуулан мөрдөж байна. Анх батлагдсан төсвийн орлогыг 7,1 тэрбум төгрөгөөр, зарлагыг 949,8 сая төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 6,2 тэрбум төгрөгөөр тус тус бүрдүүлж төлөвлөгдлөө.

Орон нутгийн төсөв, авто замын сан, Эрдэнэт сангаас санхүүжигдэх нийт ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог тухай бүрд байгуулж тендерийн бичиг баримтыг боловсруулан Сангийн яамны веб сайт, төвийн болон, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлж, нээлттэй ил тод зохион явууллаа. Нийт сонгон шалгаруулалтын ажлын үр дүнгээр Ногоон байгууламжийн хайсны батлагдсан зардлаас 12.1 сая, дээврийн засварын ажлаас 6.5 сая, Сүхбаатарын өргөн чөлөөний авто замын гэрэлтүүлгийн ажлаас 4.5 сая, нийтдээ 24.5 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллалаа.

Мөн Засгийн газрын 2009 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлээр Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн тухай сэрэмжлүүлэх мэдээг баг, хот айл, малчдад хүргэх, мэдээллийн шуурхай байдлыг хангаж гамшгаас урьдчилан сэргийлэх, учирч болох эрсдэл, хохирлыг бууруулах ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт даалгасан бөгөөд уг тэмдэглэлийн хүрээнд хавар, намрын улиралд тохиолдох цаг агаарын аюултай үзэгдлээс учирч болох хохирлоос иргэд, аж ахуйн нэгжийг урьдчилан сэргийлэх зорилгоор 6 удаа сэрэмжлүүлэх мэдээ, 21 удаа анхааруулах мэдээ, хоногийн ба хагас хоногийн тус бүр 365 урьдчилсан мэдээг зохион орон нутгийн мэдээллийн хэрэгслээр болон бичгээр холбогдох газруудад хүргэлээ. 9 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд болсон цаг агаарын онц аюултай үзэгдлийн үеэр иргэд аж ахуйн нэгжид учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай өдрүүдэд цаг тутамд шуурхай мэдээлж ажиллалаа.

2.3. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий сайдтай Орхон аймгийн Засаг дарга бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлж ажиллах 9 заалт бүхий батламж байгуулан, батламжаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл гэж үзэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэн, ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга нарын шууд хариуцан гүйцэтгэх манай аймагт холбогдох 149 арга хэмжээний заалтыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, хэрэгжүүлэх ажлыг зохион

байгуулснаар 2009 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 82.4, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 79,2 хувийн биелэлттэй хэрэгжиж байна.

Нутгийн захиргааны байгууллагыг ажил эрхлэх ур чадвар, мэдлэг боловсрол, туршлагатай, мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлэн, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид байлган иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар үйлчлэх заалтын хүрээнд:

Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 67 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрыг Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс /Хяналт шинжилгээ, үнэлгээний тасагтай/, Хууль зүйн хэлтэс /Архивын албатай/, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Цэргийн штабтайгаар шинэчлэн зохион байгуулж, Тамгын газрын даргын тушаалаар батлан үйл ажиллагаа явуулж байна.

Бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын дэргэдэх зарим газар, хэлтсийн чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт хийж, Ерөнхий менежерүүдийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж бүрэн томилоод байна.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс Шведийн төрийн захиргааны олон улсын институт /SIPU internal/-тай хамтран хэрэгжүүлж буй “Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал” сургалтын хөтөлбөрийн хүрээнд тус аймагт 5 удаагийн үндсэн сургалт зохион байгуулагдан 100 ерөнхий менежер манлайлах ур чадварыг хөгжүүлэх сургалтанд хамрагдлаа. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “Ёс зүйт манлайлал” сургалтад 20 ерөнхий менежер, “Дэлхийн зөн” ОУБ-тай хамтран зохион байгуулсан “Үйлчилдэг удирдлага” сэдэвт сургалтад 35 ерөнхий менежерүүд хамрагдлаа.

Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг байнга сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авилгал, хээл хахуультай тууштай тэмцэж ажиллах заалтын дагуу аймгийн төсөвт 32.5 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 10,2 хувиар давуулан биеллүүлэв. Өнгөрсөн оноос орон нутгийн төсвийн орлого 4.4 хувиар нэмэгдлээ. Тайлант онд аймгийн төсөв бүхэлдээ өргүй, орон нутгийн төсөв 148,2 сая

төгрөгийн ашигтай ажиллалаа. Аймгийн төсвөөс улсын төсөвт батлагдсан хуваарийн дагуу 26,2 тэрбум төгрөгийг тэгшитгэн төвлөрүүллээ.

Аймгийн бодит эдийн засгийн өсөлтийг хангахын зэрэгцээ соёл, боловсрол, эрүүл мэндийн зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж ажиллах заалтын хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант онд боловсролын салбарт 2009-2010 оны хичээлийн жилд 18 сургуулийн 586 бүлэгт (үүнээс 4 нь цогцолбор сургууль) 19.0 мянган хүүхэд суралцаж, 21 цэцэрлэгийн 169 бүлэгт 4.5 мянган хүүхэд хүмүүжиж, эдгээрт 1165 багш сурган хүмүүжүүлэгч ажиллаж байна. Өнгөрсөн оноос суралцагсад 3.2 хувиар буурч, хүмүүжиж байгаа хүүхэд 3.0 хувиар, багш 1.6 хувиар нэмэгдлээ. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын стандарт хангалт 99.3, чанар 76.9 хувьтай байгаа нь өмнөх хичээлийн жилээс стандарт хангалт 0.1 пунктээр буурсан боловч чанар 0.1 пунктээр дээшиллээ.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 60 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 13 нь өрхийн эмнэлэг, 41 нь хувийн эмнэлэг байна. Эдгээрт 250 их эмч, 488 дунд мэргэжилтэн ажиллаж байна. Хувийн хэвшлийн 7 эмнэлэг 85 ортойгоор ажиллаж байгаа нь нийт орны 20.2 хувийг эзэлж байна.

Аймгийн 10000 хүнд 27 их эмч, 53 дунд мэргэжилтэн, 46 ор, нэг их эмчид 365 хүн ногдож байна.

Эрүүл мэндийн байгууллагууд 670.5 мянган хүнд үзлэг хийснээс 42.1 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Өнгөрсөн оноос нийт үзлэг 7.8 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэг 20.5 хувиар өслөө.

Сэргийлэх тарилгад 11.8 мянган хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүний 99.2 хувь нь бөгөөд өнгөрсөн оноос хамралт 0.4 пунктээр өсөөд байна.

Тайлант онд аймгийн хэмжээнд 2489 эх амаржин, 521 хүн нас барав. Нас баралтын 7.5 хувийг нялхсын нас баралт эзэлж байна. 1000 хүнд ногдох төрөлт 2.4 промилээр, нас баралт 0.3 промилээр нэмэгдсэн ч 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2.3 промилээр буурав. Тайлант хугацаанд 1 эх эндсэн байна.

Халдварт өвчнөөр өвчилсөн 1227 тохиолдол гарсан нь өнгөрсөн оноос 13.2 хувиар буурлаа.

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 63.2 мянган хүнд 23.5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосноос 3 хүнд 2.9 сая төгрөгийн нөхөн олговор, 573 хүнд 332.0 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж, 1606 хүнд 752.0 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 1372 хүнд 348.5 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 1356 хүнд 197.1 сая төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 5881 ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 385.5 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 40859 хүнд 2.9 тэрбум төгрөгийн тэтгэмж, хөнгөлөлт, Монгол улсыг хөгжүүлэх сангаас 30855 хүүхдэд 2.9 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгө, Хүнс тэжээл хөтөлбөрийн хүрээнд 902 хүнд 25.2 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн олголоо.

Өнгөрсөн оноос халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүн 0.3 хувиар, олгосон халамжийн хэмжээ 18.1 хувиар нэмэгдлээ. Аймгийн хэмжээнд тайлант онд нийт 983 ажлын байр шинээр бий болж, ажилгүйдлийн түвшин 5,2 буюу өмнөх оны түвшинд, ядуурлын түвшин 16,2 буюу өмнөх оноос 0,2 пунктээр буурлаа.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, архи дан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга, хариуцлагыг сайжруулж өндөр шаардлагатай ажиллах заалтын хүрээнд тайлант онд согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг цэгүүдийн 73-аар бууруулав.

Тайлант онд 368 хэрэгт 412 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 55.8 хувьтай байна. Өмнөх оноос бүртгэгдсэн хэрэг 19.5 хувиар, холбогдогч 24.1 хувиар, 18 – аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 26.5 хувиар буурч, хэргийн илрүүлэлт 7.3 пунктээр нэмэгдлээ.

Нийт бүртгэгдсэн хэргийн 46.7 хувь нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг, 27.4 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 17.7 хувь нь хүнд, онц хүнд хэрэг байгаа ба өмнөх оноос согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 25.2 хувиар, бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 0.6 хувиар тус тус буурч, хүнд, онц хүнд хэрэг өмнөх оны түвшинд байна.

Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Шадар сайдаас өгсөн үүрэг, даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг туслалцааг

авч ажиллаж байгаа бөгөөд энэхүү батламжийн хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр гарган, хяналт шинжилгээ, үнэлгээ хийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан батламжийн хэрэгжилт өссөн дүнгээр 92,0 хувьтай байна.

2.4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь 4 бүлэг бүхий 79 зорилт, 397 арга хэмжээнээс бүрдэж байгаа бөгөөд эдгээр арга хэмжээнээс 2009 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт 244 асуудал тусгагдан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор салбарын төсвийн ерөнхийлөн захирагчидтай бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ, Засаг даргын дэргэдэх агентлагийн дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж ажиллав.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймагт хэрэгжиж буй үндэсний болон аймгийн хөгжлийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй нягт уялдуулах бодлогыг баримталж, Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Орхон аймгийг 2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлогыг боловсруулж батлууллаа.

Мөн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх аймгийн хөтөлбөр, Аймгийн өрхийн эмнэлгүүдийг хөгжүүлэх хөтөлбөр, “Эрүүл хот” хөтөлбөр, Аймгийн Залуучуудын хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр, “Орон нутгийн хөгжилд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоо” хөтөлбөр, Аймгийн хүн амын нийгмийн эрүүл мэндийг сайжруулах талаар баримтлах бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн жилд тавьсан зорилт **78,7** хувиар биеллээ. Хэрэгжилтийн байдлыг авч үзэхэд нийт 397 арга хэмжээнээс бүрэн биелсэн 111, 90 хувьтай 140, 70 хувьтай 63, 50 хувьтай 30, 30 хувьтай 7, 10 хувьтай 17 арга хэмжээ байгаа бөгөөд тодорхой үр дүнд хүрээгүй 13 ажил байна. Аймгийн Засаг даргын үйл

ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2010 оноос хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн болон дээд шатны байгууллагын шийдвэрийн улмаас хэрэгжих хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 16 арга хэмжээ байна.

Нийгмийн хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудлын хүрээнд 24 зорилтыг хэрэгжүүлэх 132 арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 2009 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 64 арга хэмжээг тусган хэрэгжүүллээ.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 56 дугаар тогтоолоор аймгийн Нэгдсэн эмнэлгийг түшиглүүлэн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийг байгуулж, удирдлага, зохион байгуулалтын асуудлыг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 360 дугаар тушаалаар шийдвэрлэсэн.

Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах мэргэжлийн боловсон хүчнийг чадавхижуулах асуудал чухлаар тавигдаж байгаа бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд салбарын яам, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж 3 нэр төрлийн эмчилгээ, оношилгооны аппарат бусад техник хэрэгсэлээр хангасны дээр холбогдох эмч, мэргэжилтний мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг дэс дараатай авч байна.

Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн орны тоог нэмэгдүүлэх байрны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрыг орон нутгийн өмчийн байранд шилжүүлэн байрлууллаа.

Баян-Өндөр сумын Дэнж багийн нутагт 2008 оноос улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж эхэлсэн 40 ортой эмнэлгийн барилга нь 2009 онд хөрөнгийн эх үүсвэргүйгээс бүрэн зогссон байсан бөгөөд дутагдалтай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх асуудлыг холбогдох газруудад тавьж хөөцөлдсөний үр дүнд шаардлагатай санхүүжилт 300 сая төгрөгийг улсын төсвөөс гаргуулан, барилгын ажил 75 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Тайлант оны 10-р сараас А хүрээний H1N1 томуу төст вирус халдварт өвчний анхны шинж тэмдэг илэрсэн үед өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хорио цээрийн дэглэмийг оновчтой авч хэрэгжүүллээ. Уг өвчин гарсантай холбогдуулж Засгийн газар, улсын онцгой комисс болон Эрүүл мэндийн яам, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д асуудал тавьж

Амьсгалын аппарат 3-ыг нийлүүлж Вируслогийн иж бүрэн лабораторийг авч суурилуулан, түүнийг ажиллуулах мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулав. .

Аймгийн хэмжээнд ажил идэвхтэй хайж бүртгүүлсэн 2006 иргэн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 13.7 хувиар буюу 242 хүнээр нэмэгдсэн байна.

Тайлангийн хугацаанд 400-аад аж ахуйн нэгж, байгууллагад 3155 ажлын байр бий болсон /үүнээс 983 нь шинээр бий болсон/ бөгөөд 1840 иргэнийг хөдөлмөр зуучлалын шугамаар ажилд зуучлан оруулав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 78 аж ахуйн нэгж, иргэнд 294.5 сая төгрөгийн зээлийг олгож, үүний үр дүнд 350 ажлын байр бий боллоо. Мөн 30 аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран нийтийг хамарсан ажил зохион байгуулж 750 иргэнийг хамруулан тэдэнд 100.6 сая төгрөгийн ажлын хөлс олгов.

Хаврын тэргүүн сар- Цагаан сарын баярыг тохиолдуулан аймгийнхаа 70-аас дээш насны 2160 ахмадад хүндэтгэл үзүүлэхэд орон нутгийн төсвөөс 11.7 сая төгрөгийг зарцууллаа.

Мөн 476 ахмадыг ахмадын сувилал болон зуны саам сувилалд амрааж сувилахад 22.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Ахмадын бие даасан сувилалыг барих байгуулах ажлыг 2008 оноос эхлүүлсэн бөгөөд үлдэгдэл хөрөнгө болох 105,0 сая төгрөгийг 2010 оны төсөвт тусган батлуулаад байна.

Аймгийн хэмжээнд 2009 онд нийгмийн эмзэг бүлгийн орон гэргүй нэн ядуу амьдралтай 59 өрхөд иж бүрэн гэр олголоо.

Эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд эдийн засгийн салбар дахь бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, технологийн шинэчлэлийг гүнзгийрүүлж бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжилтийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх зорилго тавин ажиллаж байна. Энэ бүлэгт 23 зорилтыг хэрэгжүүлэх 121 арга хэмжээ төлөвлөгдсөнөөс аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 96 арга хэмжээ тусгагдан хэрэгжилтийг зохион байгуулав.

Орон нутгийн төсвөөс 323.9 сая, урьд оны төсвийн шилжих үлдэгдлээс 381.1 сая, Замын сангаас 308.0 сая, “Эрдэнэт сан”-гаас 280.5 сая, нийт 1252.1 сая, Улсын төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангаас нийт 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийж гүйцэтгэлээ.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын ажлын сонгон шалгаруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль, холбогдох бусад журмын дагуу ил тод, нээлттэй зохион байгуулж, явуулсаны үр дүнд 2009 онд худалдан авах үйл ажиллагаатай холбогдсон ямар нэгэн гомдол, маргаан гараагүй болно.

Нийт сонгон шалгаруулалтын ажлын үр дүнгээр хотын ногоон байгууламжийн хайс хашлагын батлагдсан зардлаас 12.1 сая, орон сууцны дээврийн засварын ажлаас 6.5 сая, Сүхбаатарын өргөн чөлөөний гэрэлтүүлгийн шинэчлэлтийн ажлаас 4.5 сая, нийтдээ 26.9 сая төгрөгийн хэмнэлт гаргалаа.

Засгийн газраас 2009 оныг “Үйлдвэржилтийн жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн ажлын хэсгийг байгуулж, жилийн ажлын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган тодорхой ажлуудыг зохион байгууллаа. Жилийн ажлын хүрээнд “Орхон аймагт хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэл”-ийг батлан гаргалаа. Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санд орон нутгийн төсвөөс 30 сая, улсын төсвөөс 530.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж тус сангаас 2009 онд нийтдээ 46 төсөлд 780.0 сая төгрөгийн зээл олгов.

Үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2009 онд “Хөх ган” ХХК-ийн төмрийн хүдэр боловсруулах үйлдвэр, “Эрдэнэт төгөл” ХХК-ийн барилгын материалын үйлдвэр, “Цэвэр металл” ХХК-ийн ган бөмбөлөгийн үйлдвэр, өнгөлгөөний хавтан, дээврийн хуванцар хавтан, талх нарийн боовны цех гэх мэтчилэн 71 үйлдвэр, үйлчилгээний цэг салбар шинээр байгуулагдаж, тэдгээрт нийтдээ 400 гаруй ажлын байр шинээр бий болов.

Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг үнийн хөөрөгдлөөс сэргийлэх зорилгоор “Эрдэнэт прогресс”, “Монгема” ХХК-иудаар 500 тн мах бэлтгүүлэн нөөцөлж, хавар 3-6-р саруудад 6 цэгээр дамжуулан иргэдэд нийлүүлсэн нь махны үнэ, хангалтыг тогтвортой байлгав.

“Атрын III аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газар тариалангийн салбарт техник, технологийн дорвитой шинэчлэл хийх эхлэл тавигдаж техникийн парк шинэчлэх, усалгаатай тариалан эрхлэх, хамгаалагдсан хөрсний тариалан эрхлэх чиглэлээр “Бүтлийн ундарга”, “Орхон тариа”, “Алтан тошлой”

зэрэг аж ахуйн нэгжүүд, өрхийн тариалан эрхлэгчид 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Үр тарианы үйлдвэрлэл голлон эрхэлдэг 3 аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 1.2 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээл олгосны зэрэгцээ улаан буудайн үрийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон нь үр тарианы аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн үр ашгийг сайжруулахад чухал түлхэц боллоо.

Атрын III аяны хүрээнд газар тариалангийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд энэ онд 10861 тн үр тариа, 6519 тн төмс, 4415 тн хүнсний ногоо хураан авлаа.1 га-гаас 24.0 цн үр тариа, 96.9 цн төмс, 101.1 цн хүнсний ногоо хураан авсан нь нэгжээс хамгийн өндөр ургац авсан 1986 онтой харьцуулахад үр тариа 8.5 цн-ээр буюу 1.6 дахин нэмэгдсэн байна.

Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг өсгөх зорилгоор энэ онд 124 өрхөд хүнсний ногооны 62 кг, төмсний 1.5 тн үр олгож тариалан эрхлэлтийг дэмжсэн нь зохих үр дүнгээ өглөө.

Манай аймгийн онцлогоос хамаарч эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариалан болон хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, нэгжээс авах ашиг, шимийг нэмэгдүүлэх бодлого баримталж байна. 2009 онд “Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих журам”, “Зоорь, хүлэмжийн аж ахуйг дэмжих журам”-уудыг батлан гаргаж ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд сурталчлах мэдээлэх ажлыг зохион байгуулснаар 450 тн-ын багтаамж бүхий 6 зоорь, 1000м² шилэн хүлэмж, 480 м² нийлэг хальсан хүлэмжүүд шинээр баригдаж ашиглалтад орлоо.

Бэлчээр нутгийн хомсдолтой байдлыг харгалзан малын толгойн тоон өсөлтөд анхаарахаас илүүтэйгээр үүлдэр угсааг сайжруулж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нь мал аж ахуйн салбарт баримталж байна.

Аймгийн хэмжээнд 28 эрчимжсэн фермерийн аж ахуй ажиллаж байгаагаас сүүний чиглэлийн 4 аж ахуй 2009 онд байгуулагдлаа. Энэ онд 10 аж ахуйн нэгж, иргэний эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх төслийг дэмжиж Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих сангаас 185 сая төгрөгийн зээл олгуулав.

Засгийн газраас баталсан “Цагаан тоос” хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Хангал голын дагуу хорио цээрийн бүс тогтоож,

хаягдлын аж ахуйн орчимд 4.9 км урт 28 м өргөн ойн зурвас байгуулж, бусад холбогдох арга хэмжээг авч байна.

Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор шингэрүүлсэн шатдаг хийг хэрэглээнд нэвтрүүлэхээр “Горгаз” ХХК-тай хамтран 150 аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээнд 34500 кг, иргэдийн хэрэгцээнд 10500 кг шатдаг хийг нийлүүлэв.

Гэр хорооллын айл өрхүүдэд хүрч байгаа цахилгаан эрчим хүчний хүчдэлийн хэмжээг нэмэгдүүлж цахилгааны эрчим хүчээр орон байрыг халаах, хэрэглээг өсгөх замаар агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог цөөрүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлын хүрээнд авто тээврийн оношлогооны стандартад нийцсэн барилга, тээврийн үйлчилгээний “Авто вокзал” барих асуудал улсын төсөвт тусгагдсан боловч санхүү, төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалж хэрэгжээгүй байна.

Хот байгуулалтын бодлогыг өмчийн олон хэлбэрийн оролцоонд тулгуурлан хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах эрүүл, цэвэр орчинг бүрдүүлэх зорилгыг хүрээнд:

2009 оныг аймгийн хэмжээнд **“Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”** болгон зарлаж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын идэвх санаачлагыг өрнүүлэн хамтарч ажилласнаар хотын ногоон байгууламж 13.1 мянган мод, бут сөөгөөр, 11.4 мянган м² зүлэгжүүлсэн талбайгаар нэмэгдэж, 4871 м урт хайс, хашлагыг шинээр буюу шинэчлэн хийлээ.

Хотын доторх болон захын хорооллуудын авто замыг сайжруулах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр Дэнж, Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт баригдахаар төлөвлөгдсөн 3.5 км авто замаас 2009 онд 2.1 км замын шороон даланг барьж, 1.4 км хатуу хучилттай асфальтан замыг барив.

Аймгийн замын сангийн хөрөнгөөр Уурхайчны гудамжны авто замыг төв замтай холбох Улаан-Үдийн гудамжны автозамыг XI хороололыг замтай холбох хатуу хучилттай авто замуудыг барьж ашиглалтанд оруулсны зэрэгцээ, гэр хороололын хатуу хучилттай авто замаас гудамж руу орох 13 орц, гарцыг шинээр барьж байгууллаа.

Хотын төв гудамж-Сүхбаатарын өргөн чөлөөний гэрэлтүүлгийг шинэчилсэний зэрэгцээ шинээр тавигдсан авто замуудын гэрэлтүүлгийг хийж, Их залуу багт шинээр

буусан айл өрхүүдийн цахилгаанжуулалтыг хийх, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийтдээ 240.0 орчим сая төгрөг зарцуулсаны 164.8 сая төгрөгийг нь орон нутгаас санхүүжүүллээ.

Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэтгэлийг Франц улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр гүйцэтгэх ажил эцэслэн шийдвэрлэгдэж бүтээн байгуулалтын ажил 2010 оны 3-р сараас эхлэхээр боллоо.

Төрийн байгууллага, албан хаагчдын ил тод, нээлттэй шуурхай,шударга байдлыг хангаж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх зорилтын хүрээнд үйл ажиллагааны хөтөлбөрт 9 зорилтыг хэрэгжүүлэх 63 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ.

Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл зэрэг төрийн төв байгууллагуудтай хамтран “Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Төрийн байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангахад анхаарах асуудлууд”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн соёл, манлайлал” зэрэг сэдвүүдээр 21 удаагийн сургалт зохион байгуулан давхардсан тоогоор 600 гаруй төрийн албан хаагчийг хамрууллаа.

Төр засгийн болон аймаг, орон нутгийн бодлого шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг сайжруулах зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран 2 өдрийн сургалтыг өөрийн аймагт зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албад, сумдын Засаг дарга нарын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх журмыг шинэчлэн гаргаж мөрдөж эхлээд байна.

Төрийн анхан шатны нэгж багийг бэхжүүлэх зорилгоор “Багийн хөгжлийн сан”-г байгуулж 2008 онд 22 баг тус бүрт 1.0 сая , 2009 онд 500.0 мянган төгрөгөөр сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн зарцуулалт, үр дүнд нь хяналт тавин ажиллаж байна.

Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар болон аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, холбогдох байгууллагууд хамтран “Шударга өрсөлдөөн ба хэрэглэгчийн эрх” сэдэвт бүсийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд аймгийн Үйлдвэрчний эвлэлийн болон Ажил олгогч эздийн холбоо хамтарсан 3 талт хэлэлцээрийн дагуу тодорхой ажлуудыг зохион байгууллаа.Аймгийн залуучуудын холбоотой хамтран “Аймгийн залуучуудын хөгжлийн

2009-2012 он хүртэлх дунд хугацааны хөтөлбөр"-ийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Оюутны холбоотой хамтран Хангайн бүсийн их, дээд сургуулиудын дунд ерөнхий эрдмийн олимпиадыг уламжлал болгон зохион явууллаа.

“Гал голомт” үндэсний хөдөлгөөний Орхон аймгийн салбар, Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн аймгийн салбар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн холбоодтой хамтарч тодорхой зорилтот сургалтуудыг зохион байгуулав.

Улаан-Үд хотын Хурал захиргааны болон ахмадын байгууллага, БНСУ-ын Хвансон, БНХАУ-ын Бугат хотын төлөөлөгч, уран бүтээлчид манай аймагт айлчилсан бөгөөд БНУУлсын Секешфехервар хотноо зохиогдсон “Хааны бүжгийн олон улсын өдрүүд” наадамд “Эрдэнэт” дуу бүжгийн чуулгын уран бүтээлчид амжилттай оролцов.

Тайлангийн хугацаанд аймаг, сумдын засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 11942 өргөдөл, гомдол ирсний 1890 нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 10052 буюу 84.1 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ.

Дээрх өргөдөл, гомдлын 358 нь гомдол, 11584 нь өргөдөл, хүсэлт байна. Ирсэн гомдлын ихэнх хувь нь хувийн хэвшлийн байгууллагууд цалин хөлс дутуу буюу буруу бодож олгосон, газрын маргаан, Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаа, орон сууцны дээврээс ус гоожиж байгаа болон дээд давхрын айлаас ус алдсан тухай гомдол байна.

Төрийн үйлчилгээнд нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд нэг цэгээс хэд хэдэн үйлчилгээг авч, тэдний цаг хугацаа, хөрөнгө мөнгийг хэмнэх төдийгүй, үйлчилгээ нь шуурхай, нээлттэй болох боломж бүрдээд байна. Тайлангийн хугацаанд тус төвөөр нийт 20000 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлээ.

2009 оны байдлаар **368** гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеийнхээс 29,5 хувиар буурсан, илрээгүй гэмт хэрэг 76 байгаа нь өмнөх оноос өссөн, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 101 гарсан нь 25,2 хувиар буурсан, насанд хүрээгүй хүүхэд 27 байгаа нь 43,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас нас барсан хүн 17, гэмтсэн хүн 152, нийт учирсан хохирол 953,5 сая төгрөг, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь 96.2 байна.

“Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн туслалцааны төвийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн дэмжлэгтэйгээр байгуулан ажиллаж байна.

Төв байгуулагдсанаас хойш эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй 83 хүний эрүүгийн хэрэгт өөрсдийнх нь хүсэлтээр өмгөөлөгчөөр оролцож шүүх, прокурорын шатанд хэргийг нь шийдвэрлүүлсэн байна.

Эрх зүйн туслалцааны төвийн сургалтын танхимыг аймгийн Засаг даргын Тамгын газарт ашиглалтад оруулж, Эрх зүйн албан бус сургалтыг хуваарийн дагуу нийт 39 удаа зохион байгуулж 510 гаруй төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг хамрууллаа.

Цагдаагийн хөдөлгөөнт эргүүлийг оны хэнээс байгуулан ажиллуулсан нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, иргэдийн амгалан, тайван амьдрах боломжийг бүрдүүлэхэд үр дүнгээ өгч, гудамж талбайд танхайрах, булаах, дээрэмдэх хэргүүд буурч байна.

Гурав: Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

3.1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн Ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

3.1.1. Шадар сайдтай байгуулсан гэрээний үр дүн

Тайлант онд Үр дүнгийн гэрээгээр аймгийн Засаг дарга Монгол Улсын Шадар сайдад хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр 3 бүтээгдэхүүний ангийн 16 нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэхээр тохиролцон гэрээний дагуу зохих хугацаанд нийлүүллээ.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан багийн Засаг дарга нарын бүрэн эрхийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийв. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Баян-Өндөр сумын 19 багийн Засаг дарга нар бүрэн хамрагдаж, хангалттай үнэлэгдэв.

Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн зорилтыг хангах 3 дахь шатны үйл ажиллагааны чиглэлийн хэрэгжилтэд 5 зорилтын хүрээний 38 үзүүлэлтээр мониторинг хийж, мэдээллийн цахим сантай болов.

Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг шинэчлэн гаргасан бөгөөд бүтэн өнчин 261, үүнээс Энэрэл төвд 47, эцэг эхийн хараа хяналт сул 18, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 328, хөдөлмөр эрхэлдэг хүүхэд 117, нэн ядуу өрхийн 6870 хүүхэд байна.

Аймгийн Хүүхдийн ордоныг үргэлжлүүлэн барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд 2010 онд ашиглалтанд орох боломжтой болсон зэрэг гэрээнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлэв.

3.1.2. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээний үр дүн

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдтай аймгийн Засаг дарга 5 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ байгуулж, уг бүтээгдэхүүнийг нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган биелэлтийг улирал бүр тооцон ажиллалаа.

Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэлийг гаргасан бөгөөд Орхон аймгийн нийт газар нутгийн хэмжээ 84,4 мянган га, үүнээс 46,5 мянган га нт хөдөө аж ахуйн газар, 20,9 га нь хот тосгон, бусад суурин газар, 960 га нь зам, шугам сүлжээний газар, 15,5 мянган га нь ойн сан, 221,5 га нь усны сан бүхий газар, 139 га нь тусгай хэрэгцээний газар байна.

Аймгийн 2009 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, аймгийн ИТХ-ын ээлжит III хуралдаанаар хэлэлцүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

Иргэн, аж ахуйн нэгжид аж ахуйн зориулалтаар газар эзэмшүүлэх зорилгоор дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж Баян-Өндөр сумын Согоот багийн нутагт авто засвар үйлчилгээний зориулалтаар 0,045 га газрыг дуудлага худалдаагаар, Уртбулаг багийн нутагт нэгдсэн гарашийн зориулалттай 0,08 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар, Говил багийн нутагт үйлдвэрлэлийн зориулалтаар 0,1 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар тус тус эзэмшүүллээ.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийг хэрэгжүүлэх, аймгийн нутаг дэвсгэрт иргэний гэр бүлийн хэрэгцээнд газар олгох ажлын хүрээнд иргэдийн өргөдлийг хүлээн авч тайлант онд Баян-Өндөр сумын 813 иргэнд 62,49 га газар, Жаргалант сумын 185 иргэнд 24,05 га газрыг тус тус өмчлүүлээд байна.

Зам тээврийн чиглэлээр нийт 5 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээнд тусгагдсан бөгөөд ахмадын тээврийн үйлчилгээнд давхардсан тоогоор 178,9 мянган ахмад

тээвэрлэж, 1868,7 мянган хүн/км-ын ажил үүрэг гүйцэтгэв. Уг үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 21,0 сая төгрөг зарцуулав.

Оюутан сурагчдад хөнгөлөлттэй үнээр нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 2,8 сая төгрөг зарцуулж, хөнгөлөлт үзүүллээ.

Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй стандартын шаардлага хангахгүй байгаа тээврийн хэрэгслүүдийг үйлчилгээнээс хасах бодлогын хүрээнд 1991-1993 онд үйлдвэрлэгдсэн 155 суудлын автомашин, 1994-1995 оны 48 бага оврын автобусыг үйлчилгээнээс хасч, 32 микроавтобус, 128 суудлын тээврийн хэрэгслийг үйлчилгээнд оруулав. Мөн 2009 оноос Эрдэнэт хотод шинээр дуудлагын таксийн үйлчилгээг нэвтрүүлж, такси үйлчилгээг 100 хувь синфоржууллаа.

3.1.3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээний үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчтай аймгийн Засаг дарга “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ” байгуулан ажиллаж 2009 оны төсвийн нийт зардал 57126,2 мянган төгрөг, тусгай захиалгат бүтээгдэхүүн 24 000,0 мянган төгрөгийг үндэслэсэн болно.

Тайлант хугацаанд 49 бүтээгдэхүүнийг нийлүүлэхээр аймгийн Засаг дарга эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчтай гэрээ байгуулан ажиллалаа. Тохиролцсон үр дүнгээр гарсан зөрүү байхгүй болно. Гэрээг хэрэгжүүлэн ажилласнаар:

Ойн сангийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Ойн газрын дарга нараар батлуулан хэрэгжүүлж ажиллав.

Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан иргэд, аж ахуйн нэгжтэй гэрээг шинэчлэн байгуулав.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын шийдвэрийн дагуу Жаргалант сумын Урт нүүр гэдэг газар 150 га талбайд ойжуулалт хийлээ.

Мөн Жаргалант сумын Шувуутын амны булгийн эхийг хамгаалж, тохижуулах ажлыг сонгон шалгаруулалт явуулж, гүйцэтгэн хүлээн авч, материалыг Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлэв.

Цагаан тоос хөтөлбөрийн хүрээнд цагаан тоостой бүсэд амьдарч байгаа иргэдийн эрүүл мэндэд хяналт тавьж, 25 иргэнийг эрүүл мэндийн иж бүрэн нарийн үзлэг шинжилгээнд хамруулж эмч нарын зөвлөгөөнөөр хэлэлцэж дүгнэлт гаргалаа. Үзлэгийн дүнгээр эрүүл 3, ямар нэгэн өвчлөлтэй 22 хүн байгаагаас дийлэнх буюу 27 хувь нь цагаан мөгөөрсөн хоолойн архаг үрэвсэлтэй болох нь тогтоогдлоо.

“Байгаль хамгаалах сарын ажлыг “Гялгар уутны хэрэглээнээс татгалзъя” уриан дор тусгай төлөвлөгөөг батлан мэдээлэл, ухуулга, сурталчилгааны ажлыг зохион байгуулав.

3.1.4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан гэрээний үр дүн

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хүрээнд “Шувууны томуу, хүний цар тахалтай тэмцэх” төслөөс 98,0 мянган ам.долларын хөрөнгө бүхий лаборатори, тоног төхөөрөмж нийлүүлэн үйл ажиллагааг нь эхлүүллээ.

Мал сүргийг халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх эмчлэн эдгэрүүлэх, малын зүй бус хорогдлыг багасгах, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бог малд ангилалт хийх, хээлтэгч, хээлтүүлэгч малд үзлэг хийх, шинээр өсвөр хээлтүүлэгч сонгон тавих, хоршоо, фермерийн аж ахуйг үүсгэн байгуулах, дэмжих, мал сүргийг байгалийн эрсдлээс хамгаалах, малчдад хүн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, усалгаатай газар тариаланг өргөтгөх, хаврын тариалалтын бэлтгэлийг хугацаанд нь хангаж, чанартай үр нийлүүлэх, тариалалтыг агротехникийн зохистой хугацаанд нь хийх, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд нийцсэн бодлого зорилтыг тодорхойлж, түүний дагуу бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг байгуулж ажиллав.

3.1.5. Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний үр дүн

Тайлант онд давхардсан тоогоор 670480 амбулаторийн үзлэг хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 48598 буюу 4,5 хувиар нэмэгдэж, урьдчилан сэргийлэх үзлэг 42,1 хувьтай байна. 2009 онд 2489 эх амаржиж өмнөх оны мөн үеэс 1000 хүнд 27,7 буюу өмнөх оноос 2,4-өөр, гэрийн төрөлт 14 тохиолдлоор буюу өмнөх оны мөн үеэс 0,6-аар тус тус нэмэгдлээ. Амьгүй төрөлтийн түвшин 8,2 байна.

Эмнэлгийн нас баралт нь нийт нас баралтанд эзлэх хувь 16,1-ээр буурч, эмнэлгийн хоног болоогүй нас баралт 33,8 байгаа нь өмнөх оныхоос 16,2 хувиар тус тус буурсан. Халдварт өвчнөөр өвчилсөн 1227 тохиолдол гарч 10 000 хүн амд 136,5 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 13,9 промиэлоор буурсан. Урьдчилан сэргийлэх тарилгад

11789 хүүхдийг 99,2 хувийн хамралттайгаар зохион байгуулав.Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 121705 хүнд үйлчилсэн байна.

Эрүүл мэндийн сайдтай Орхон аймгийн байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 90 хувь хэрэгжсэн байна.

3.1.6. Хууль зүй дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний үр дүн:

Хууль зүйн дотоод хэргийн сайдад аймгийн Засаг даргаас 29 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гурвалсан гэрээ байгуулан ажиллав. Уг гэрээний хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2009 оны 02 дугаар сараас хөдөлгөөнт эргүүл ажиллуулахаар шийдвэрлэж, автомашинаар ханган, шатахууны асуудлыг шийдвэрлэж өглөө. Эрүүлжүүлэх байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах зорилгоор эрүүлжүүлэх баривчлах байрны засварын зардалд 2,5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж өглөө.

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаас Цагдаагийн газраас зохиож буй ажил, цаашид авах арга хэмжээ, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажлын талаар Цагдаагийн газрын даргын илтгэлийг хэлэлцэж, согтуурал хэмжигч багаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, санамж хэвлүүлэх зардлыг шийдвэрлэж, орон тоог нэмэгдүүлэх асуудлыг Хууль зүй дотоод хэргийн яаманд тавьлаа.

Олон нийтийг хамарсан арга хэмжээ, төрийн албан ёсны хамгаалалтын үйл ажиллагааг 86 удаа зохион байгуулж, уг арга хэмжээний зардалд 2,0 сая төгрөг зарцуулав.

3.1.7. Батлан хамгаалахын Сайдтай байгуулсан гэрээний үр дүн:

Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах болон цэргийн шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлэх, бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцсэн орон нутгийн хамгаалалтын удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх зорилтын хүрээнд 9 заалт бүхий гэрээ байгуулан ажиллалаа.

Тайлангийн хугацаанд цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулж хамрагдвал зохих иргэдийн 97.2 хувийг хамруулан Зэвсэгт хүчний жанжин штабт хүргүүлээ.

Дайчилгааны даалгаврын дагуу 15 командын хүн хүч, техникийг Зэвсэгт хүчний 186 дугаар ангитай тодотгол хийж, дайчилгааны бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа. Баян-Өндөр, Жаргалант сумд, 15 аж ахуйн нэгж байгууллагад хүн хүч, техникийн дайчилгааны даалгавар өгөв.

2009 онд эрүүл мэндээр чөлөөлөгдсөн иргэдийг эмнэлгийн хяналтанд авч картжуулан эрүүлжүүлэх арга хэмжээ авч байна. Тайлангийн хугацаанд хавар, намрын цэрэг татлагыг зохион байгуулж Зэвсэгт хүчний жанжин штабаас өгөгдсөн хяналтын тоог 98.5 хувиар биелүүлж, 3,2 сая төгрөг зарцууллаа.

3.1.8.Боловсрол, соёл шинжлэх ухааны Сайдтай байгуулсан гэрээний үр дүн:

Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлэхийн тулд дараахь хүчин зүйлүүд дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулж ирлээ. Үүнд: Боловсролын салбарын удирдах ажилтан болон боловсон хүчний манлайлах ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгох бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Боловсрол соёлын газарт “Хяналт шинжилгээ үнэлгээний баг” байгуулан ажиллуулснаар гарч буй ололт дутагдлыг цаг үед нь илрүүлэн үйл ажиллагаандаа дүгнэлт хийн, мэдээлэл судалгаагаар хангагдаж байна.

2009-2010 оны хичээлийн жилд 18 сургуулийн 586 бүлэгт 19.0 мянган хүүхэд суралцаж, 21 цэцэрлэгийн 169 бүлэгт 4.5 мянган хүүхэд хүмүүжиж, эдгээрт 1165 багш сурган хүмүүжүүлэгч ажиллаж байна. Өнгөрсөн оноос суралцагсад 3.2 хувиар буурч, хүмүүжиж байгаа хүүхэд 3.0 хувиар, багш сурган хүмүүжүүлэгч 1.6 хувиар нэмэгдлээ. Нийт багш нарын 84.9 хувь нь ерөнхий боловсролын дунд сургуульд, 15.1 хувь нь цэцэрлэгт ажиллаж байна.

4 их, дээд сургуульд 3.3 мянган оюутан суралцаж байгаагийн 86.5 хувь нь их сургуульд сурч байна. Эдгээр их дээд сургуульд 169 орон тооны багш сургалт явуулж байна. Оюутнуудын тоо өмнөх хичээлийн жилээс 8.6 хувиар багаслаа.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын стандарт хангалт 99.3, чанар 76.9 хувьтай байгаа нь өмнөх хичээлийн жилээс стандарт хангалт 0.1 пунктээр буурч, чанар 0.1 пунктээр дээшилсэн.

Тайлант онд давхардсан тоогоор 118.0 мянган хүүхдийг хамруулан урлаг, спорт, хүмүүжлийн 175 ажил зохион явуулснаар, өнгөрсөн оноос хамрагдсан хүүхэд 16.3 хувиар

буурсан ч зохиосон ажил 3.6 хувиар өслөө. Хүүхдийн 3 зусланд 2680 хүүхэд амарсан нь өмнөх оныхоос 27.6 хувиар нэмэгдсэн байна.

3.2. Төсвийн Ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Аймгийн Засаг дарга 2009 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга нартай “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ” байгуулан ажиллаж, жилийн эцэст Баян-Өндөр сумын Засаг дарга 92,8, Жаргалант сумын Засаг дарга 83,0 хувийн үнэлгээтэй дүгнэгдэв.

Тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх 22 агентлаг төсвийн Ерөнхийлөн захирагчтай Үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж нийт 17 Ерөнхий менежер буюу 78,0 хувь нь “А” үнэлгээтэй дүгнэгдлээ. Үнэлгээний дүнг үндэслэн Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Биеийн тамир, спортын газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Хотын захирагчийн алба, Тээвэр, авто замын газрын Ерөнхий менежерүүдэд зэрэг дэв олгох арга хэмжээ авлаа.

***Дөрөв: Байгууллагын үйл
ажиллагааны ил тод байдлын үнэлгээ***

4.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэх, үйлчилгээг шуурхай, нээлттэй хүргэх зорилгоор аймгийн хэмжээнд 7 байгууллагын үйлчилгээг хамруулан “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлж, нийт 21000 гаруй хүнд үйлчилгээ үзүүлээд байна. Уг үйлчилгээг нэвтрүүлснээр үйлчлүүлэгчийн цаг хугацаа, хөрөнгө мөнгийг хэмнээд зогсохгүй үйлчилгээ нь хяналттай, нээлттэй, хүртээмжтэй болж, иргэдийн талархлыг хүлээсэн чухал ажил боллоо.

Тайлангийн хугацаанд “Төрийн үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамж” сэдэвт форумыг аймгийн хэмжээнд 3 цэгт зохион байгуулж, төрийн байгууллагуудын удирдлага болон 300-аад иргэдийг оролцуулан тэдний санал хүсэлтийг сонсож төрийн үйлчилгээнд доголдож буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцлээ. Мөн аймгийн нийгмийн хамгааллын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, газрын харилцааны асуудлыг боловсронгуй болгох нь сэдэвт форум хэлэлцүүлгийг 6 цэгт зохион байгуулж нийт 400 гаруй иргэдийн санал хүсэлтийг сонсон, дээрх асуудлуудыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргууллаа.

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 13 дугаар албан даалгаварын мөрөөр төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад аймгийн хэмжээнд иргэдийн санал, хүсэлтийг сонсож, бодлого шийдвэрт тусгах, хэрэгжүүлэх, төрийн байгууллагаас хийж буй ажлыг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор төрийн байгууллагуудад “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулах журам, хуваарийг батлан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Тайлангийн хугацаанд төрийн болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч 32 байгууллага 2-9 удаа “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж төрийн байгууллагууд иргэдтэй уулзалт зөвлөгөөн зохион байгуулах, иргэдийн санал, хүсэлт, зөвлөмжийг саналын хайрцаг болон хуудсаар авах, нээлттэй утас ажиллуулах, төрөл бүрийн хууль эрх зүйн чиглэлээр гарын авлага, товхимол бэлтгэн иргэдэд тараах, төрийн ажил үйлчилгээг сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг сонсох, асуудлыг газар дээр нь шийдвэрлэх, тэдний санал зөвлөмжийг төрийн байгууллагуудын бодлого, шийдвэрт тусган хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авлаа. Тухайлбал газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний төслийн анхны хувилбарыг иргэдэд танилцуулж тэдний саналыг авч, түүвэр судалгаа явуулан санал хүсэлтийг нь хот байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ирлээ.

Мөн сумын ЗДТГ, багууд, ХХҮХэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Арилжааны банк зэрэг байгууллагууд хамтран “Эрдэнэт хивс”ХК, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий үйлдвэрлэлийн цэгт Нээлттэй хаалганы өдрийг 2 удаа зохион байгуулж төрийн үйлчилгээг үзүүлсэн нь үйлдвэрийн ажилчдад төрийн үйлчилгээг ойртуулсан үр дүнтэй ажил болсон. Нээлттэй хаалганы өдрүүдээр иргэдээс нийт 4000 гаруй санал хүсэлт ирснийг хүлээн авч шийдвэрлэв.

Аймгийн хэмжээнд “Орон нутгийн хөгжилд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо” хөтөлбөрийг боловсруулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр батлуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж эхлээд байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Иргэд хүлээн авах байр”-ыг ажиллах журмын дагуу тогтмол ажиллуулан тус байран дахь хууль эрх зүйн санд байнга баяжилт хийж иргэдийг цаг үеийн болон хууль эрх зүйн мэдээлэл авах, санал хүсэлтээ биечлэн ирж болон Иргэд хүлээн авах байрны утсаар илэрхийлэх боломжоор ханган өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдвэрлэж ирлээ.

Тайлангийн хугацаанд аймгийн ЗДТГ-ын Иргэд хүлээн авах байраар нийт 611 иргэн үйлчлүүлснээс аймгийн удирдлагууд нийт 256 иргэнийг биечлэн хүлээн авч уулзан өргөдөл, санал, хүсэлтийг нь хүлээн авч, шийдвэрлэж хариу өгөв.

Иргэдээс гарч буй өргөдөл, гомдол, санал, хүсэлтэнд өндөр ач холбогдол өгч тэднээс гарсан санал, хүсэлтийг аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогын асуудалд тусган хэрэгжүүлэх талаар байнга анхааран ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 1851 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсний 675 нь амаар, 1176 нь бичгээр ирсэн байна. Үүний 1848 нь өргөдөл хүсэлт, 3 нь гомдол байна.

Дээрх өргөдөл, гомдлын 10 нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 1841 буюу 99,4 хувь нь хуулинд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн байна. Засгийн газрын 2008 оны 72 дугаар тогтоол гарсантай холбогдуулан ахмад дайчид болон тэдний ар гэрээс ирүүлсэн 36 өргөдлийг НХХЯ болон БХЯ-д шийдвэрлүүлэхээр уламжиллаа.

4.2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг Тамгын газрын даргын 2009 оны 08 сарын 27-ны өдрийн 76 дугаар тушаалын хавсралтаар батлан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр нь 2009-2017 оныг хамрах ба 2009-2011, 2012-2014, 2015-2017 он гэсэн 3 үе шаттайгаар, дунд хугацааны стратеги төлөвлөлттэйгээр хэрэгжинэ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн хэрэгцээг хангахдаа нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулалт явуулж, ирээдүйд шаардагдах албан тушаал, орон тоо, мэдлэг, ур чадвар ба зардлыг тусгасан байгууллагын хүний нөөцийн стратеги төлөвлөлт хийх ба энэхүү төлөвлөгөө нь дээрх хөтөлбөр болон байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт болон стратегид үндэслэнэ. Аймгийн Засаг даргын Тамгын газрын болон нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албаны сул орон тооны захиалгыг /Төрийн албаны зөвлөлөөс төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласнаас гадна/ орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 21-ээс доошгүй хоногийн хугацаагаар зарлаж байна.

Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг ТАЗ-өөс тогтоосон стандартын дагуу үнэлж дүгнэж байгаа ба аймгийн Засаг даргын Тамгын газрын Ерөнхий менежерийн зүгээс төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээний жилийн эцсийн

үндсэн үнэлгээ, тайлант оны ажлын гүйцэтгэл, ирэх оны зорилтын талаар гүйцэтгэлийн үнэлгээний ярилцлага хийж хэвшсэн ба үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний саналыг ажилтан бүрээр гарган хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Мөн түүнчлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журамд байгууллагын хөгжил, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулахад оруулсан хувь нэмрийг үнэлэн жил бүр 3-аас доошгүй төрийн албан хаагчийг мөнгөн шагналаар шагнаж урамшуулахаар нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулах, сургалт сурталчилгаа явуулах, гарын авлага материалаар хангах, зөвлөлгөө өгөх, бүртгэх хянах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн чиг үүрэгт хамааруулсан ба өнөөдрийн байдлаар 251 төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч хянан дүн мэдээг нэгтгэн Авилгатай тэмцэх газарт хүргүүлээ.

4.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал

2009 оны бодит гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 32 688,6 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 110,2 хувиар биелүүллээ. Төсөвт байгууллагуудын өөрийн орлогод 140 926,1 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал зардалд 3 773,3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, улсын төсөвт 26 226,2 сая төгрөгийг төвлөрүүлэн орон нутгийн төсөв 148,2 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төсөв бүхэлдээ өр, авлагагүй ажиллав.

Тайлант оны төсвийн төсөл, гүйцэтгэлийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлдэг бөгөөд тухай бүр орон нутгийн телевизээр шууд дамжуулан, тусгай утас ажиллуулан иргэдийн оролцоог хангаж хэвшлээ.

Орхон аймгийн 2009 оны төсвийг жилийн эхэнд 1 удаа, гүйцэтгэлийг жилийн эцэст 2 удаа орон нутгийн “Шинэ мэдээ” сонинд бүрэн эхээр нь нийтэлж иргэдийг мэдээллээр хангалаа. Аймгийн төсвийн орлого, зарлага, гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар телевизийн шууд нэвтрүүлэгт холбогдох албан тушаалтнууд хуваарийн дагуу оролцож, иргэдийн асуултанд хариулж ирлээ.

4.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал:

Орхон аймагт 2009 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 5,0 тэрбум төгрөгийн бараа ажил үйлчилгээ хийгдэж улсын төсвийн хөрөнгөөр 3,7 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1,3 тэрбум төгрөгийн ажил хийгдэж, тайлангийн хугацаанд 65 ажил хийгдэхээс 44 ажил буюу 67,7 хувь нь бүрэн хийгдлээ. Гүйцэтгэгч байгууллага хугацаандаа хийж чадаагүй, хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан 18 ажил 2010 онд үргэлжлэн хийгдэхээр боллоо.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын 74 хувь нь ажлаа бүрэн хийж 2,9 тэрбум төгрөгийн, орон нутгийн хөрөнгөөр хийгдэх ажлын 87,5 хувь нь ажлаа бүрэн хийж 1,1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов. 2009 онд нийт хөрөнгө оруулалтын ажилд холбогдох хуулийн дагуу тухай бүрд нь үнэлгээний хороог байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, урьдчилгаа санхүүжилтийг 30 хүртэл хувиар олгож, тухайн ажлыг ашиглалтанд өгсөн улсын болон техникийн комиссын акт, бусад холбогдох материалыг үндэслэн гэрээг дүгнэж, үлдэгдэл санхүүжилтийг олгож ирлээ. Сонгон шалгаруулалтын урилгыг хуулийн хугацаанд орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд нээлттэй мэдээлж байгаагаас гадна аймгийн www.erdenet.mn сайтад мэдээлэл тавьж байна.

Тайлангийн хугацаанд худалдан авах ажиллагааны явцад ямар нэгэн зөрчил маргаан, түүнтэй холбогдсон гомдол гараагүй бөгөөд 2009 оны тендерийн материал, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд аймгийн аудитын байгууллагаас шалгалт хийв. Аудитын дүнгээр орон сууцны дээврийн засварын ажлуудыг харьцуулалтын арга хэрэглэсэн, тендерийн баримт бичигт урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээг тодорхой заагаагүй зэрэг зөрчил гарсан бөгөөд цаашид энэ талаар анхаарч ажиллах болно.

Аймгийн Засаг даргаас Монгол улсын Ерөнхий сайдын өмнө батламжаар хүлээсэн үүрэг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж 2010 оныг аймгийн хэмжээнд “Цэвэр орчин бүрдүүлэх жил” болгох зорилт дэвшүүлэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхлээд байна.

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА

Д.ОЮУНБАТ

